

Хөвд аймгийн
Боловсролын газар



Хөвд, Ховд, Жаргалант сум, Ховд аймаг
Утас: 70435178
Email: khovd@agency.edu.mn

_____ Үүсгэн
_____ Үүсгэн
_____ Үүсгэн

Хөвд аймгийн Боловсролын газар

«2025 онд Хөвд аймгийн Боловсролын газар
Хөвд аймгийн Боловсролын газар
Хөвд аймгийн Боловсролын газар
Хөвд аймгийн Боловсролын газар

Хөвд аймгийн Боловсролын газар
Хөвд аймгийн Боловсролын газар
Хөвд аймгийн Боловсролын газар
Хөвд аймгийн Боловсролын газар



ХОВД АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН ГАЗАР

84140 Ховд, Жаргалант сум, Ховд аймаг
Email: khovd@agency.edu.mn Утас: 70435178.

2025. 12. 12 № 751

танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН САЙД
П.НАРАНБАЯР ТАНАА

2025 оны жилийн эцсийн байгууллагын
гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж
баталгаажуулан хавсралтаар хүргүүлж байна.
Хавсралт... хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ЦЭРЭНДАВАА



**БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН
БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭГ ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ**

Байгууллагын даргын 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэг нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан аргачлалыг дагаж, 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдөр igovernment.mn цахим системд тайлан бичиж боловсруулсан.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт: 2024 оны тайланг цахим системд шилжүүлсэнтэй холбоотойгоор зарим зорилт, арга хэмжээг цахим системийн аргачлалын дагуу бүртгэсэн. Тайланд нийт 13 зорилт болон 59 арга хэмжээ бүртгэгдсэн бөгөөд эдгээрийн биелэлтийг холбогдох баримт, нотолгоонд тулгуурлан 2000 тэмдэгтэд багтаан тайлагнасан.

ЗОРИЛТ	Арга хэмжээ		Дундаж					
	Биелэлт бичих	Биелэлт бичсэн	100%	90%	70%	50%	100>...>90	90>...>70
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ	17	17	15	2	0	0	0	0
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	11	11	9	2	0	0	0	0
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	31	31	28	3	0	0	0	0
НИЙТ	59	59	52	7	0	0	0	0

Энэхүү дүнгээр 98,81% биелэлттэй бүртгэгдсэн бөгөөд бүх зорилтууд амжилттай биелсэн байна. 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь өмнөх онуудаас илүү амжилттай хэрэгжиж, зорилтот арга хэмжээнүүдийг гүйцэтгэсэн гэж дүгнэх боломжтой. Удирдлагын манлайлал, бүтээлч хандлага, ил тод байдал, идэвхтэй хамтын ажиллагаа нь төлөвлөгөөний хэрэгжилтэд ихээхэн нөлөөлсөн нь тайланд тусгагдсан.

Хэрэгжилтэд гарсан саад бэрхшээл:

- Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын бүрэн хэрэгжилтгүй үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалт, төсвийн таналт, боловсон хүчний нөөц зэргээс ихээхэн шалтгаалсан гэж ажлын хэсэг үзэж байна.

- Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд цахим хэрэглээ, монгол бичгийн хэрэглээг бүрэн нэвтрүүлэх нь зайлшгүй шаардлагатай. Албаны бичиг баримт хос бичгээр хөтлөх нь сургалтын байгууллагын боловсон хүчний чадавхи сулаас шалтгаалан стандарт бус бичиг баримт ирүүлэх тохиолдол байна.
- Сургууль, цэцэрлэг, дотуур байр шинээр барих, өргөтгөл хийх арга хэмжээ: Энэ хичээлийн жилд 6 барилга ашиглалтад хүлээн авах байсан бөгөөд 5 барилга хүлээн авч, 1 барилгын гүйцэтгэл нь 70% байна.

Үнэлгээний баг өмнөх тайлангийн явцад шинжилгээ хийж, дараах дүгнэлтүүдийг гаргаж байна. Үүнд:

- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сараар болон улирлаар төлөвлөж, биелэлтийг тогтмол хянах. Биелэлт хэрэгжилтийг тухай бүр нэгжийн дарга хянаж, тасалдаж байгаа ажлуудыг тодорхойлж хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэг үзүүлэх.
- Бүтэц орон тоо, хүний нөөцөөс үл хамааран төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй. Хүний нөөцийн алдааг бууруулах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх шаардлага тулгарч байна.
- Сар, улирал бүрд үнэлгээний баг тогтмол хяналт хийж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх шаардлагатай. Хяналт, шинжилгээ хийх тогтмол механизмтэй байж, биелэлтийг сайн бүртгэн тэмдэглэх хэрэгтэй.
- 2025 оны төлөвлөлтийг igovernment.mn цахим системд бүрэн шилжүүлэх хэрэгтэй. Сар, улирлын төлөвлөлт хийж, удирдлагын үүрэг чиглэл, салбар байгууллагын болон шууд харьяалагдах байгууллагуудын төлөвлөлтөд уялдуулан ажиллах шаардлагатай.

Энэхүү тайлан нь байгууллагын жилийн гүйцэтгэлийг амжилттай дүгнэж, биелэлтийг цахим системд шилжүүлж, ил тод, нээлттэй байдлыг хангах, үйл ажиллагааг сайжруулах боломжийг олгосон. 2025 оны амжилт нь өмнөх онуудаас илүү байгааг харуулж байна. Дараа дараагийн төлөвлөлт болон хэрэгжилтэд гарсан алдаа, саадыг засаж, ажлыг илүү үр дүнтэй зохион байгуулах шаардлага байгаа гэдгийг дүгнэж байна.

ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНЭЛСЭН:

Ажлын хэсгийн ахлагч

Б.Батсайхан /Бодлогын хэрэгжилтийн даргын
/үүргийг хавсран гүйцэтгэгч/

Гишүүд:

Д.Ган-Очир /Сургалт, арга зүйн
хэлтсийн дарга/

Б.Уранчимэг /Статистик мэдээлэл, хяналт
шинжилгээ үнэлгээ хариуцсан
ахлах арга зүйч/

Б.Уугантуяа /Хөрөнгө оруулалт, төсвийн гүйцэтгэл
хариуцсан ахлах арга зүйч/

Б.Бямбарагчаа /Сургалтын орчин, хүүхдийн хоол,
үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал
хариуцсан ахлах арга зүйч/

Нарийн бичгийн дарга

Г.Алтантуяа /Хүний нөөцийн асуудал
хариуцсан ахлах арга зүйч/

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭГ БАТАЛГААЖУУЛСАН:

Боловсролын газрын даргын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч

(албан тушаал)



Төсвийн шууд захирагч

Б.ЦЭРЭНДАВАА



ХОВД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайланг хянасан:

БОЛОВСРОЛЫН САЙД
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

Тэмдэг

Төсвийн ерөнхийлөн захирагч

/П.НАРАНБАЯР/

.....

(огноо)

Тайлагнасан:

**ХОВД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**
(албан тушаал)



(гарын үсэг)

Тэмдэг

Төсвийн ерөнхийлөн захирагч

/Б.ЦЭРЭНДАВАА./

.....

(огноо)

Ховд аймгийн Боловсролын газар
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.1.	Сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ	Орон нутгийн төсөв, улсын төсөв	Эдийн засаг нийгмийн шалгуур үзүүлэлтийн боловсролын үзүүлэлтүүд	Хамран сургалтын хувь: Элсэлтийн шалгалтын хэмжээст онооны дундаж: СӨБ, ЕБС-ийн гүйцэтгэлийн дундаж хувь:	Хамран сургалтын хувь: Элсэлтийн шалгалтын хэмжээст онооны дундаж: СӨБ, ЕБС-ийн гүйцэтгэлийн дундаж хувь:	Сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж-81,59, ЕБС-ийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж-78.32, Цэцэрлэгийн үнэлгээний дундаж- 90, Цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээний дундаж-93,4 Ерөнхий боловсролын сургуулийн насны ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн ЕБ-д хамрагдалтын хувь-71,4 ЕБС-ийн мэргэжлийн багшийн хангалт-98,5	100%
1.1.1	Хүүхдийн тооны өсөлттэй уялдуулан хамран сургах тойргийг оновчтой тогтоож, бага ангийн бүлэг дүүргэлтийг 30-аас хэтрүүлэхгүй	Орон нутгийн төсөв	Хамран сургалтын хувь	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт: 89.9 Бага боловсролын	Эхний хагас жилд: Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт: 90.9	Сургуулийн өмнөх боловсролын хамралтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2025 оны хичээлийн жилд 7946 хүүхэд байгаагаас цэцэрлэгийн 249 бүлэгт 7272 хүүхэд хамрагдаж,	100%

	байлгах, сургуулийн ачааллыг зохистой түвшинд барих.			хамран сургалт: 96.4 Суурь боловсролын хамран сургалт: 96.2	Бага боловсролын хамран сургалт: 97.4 Суурь боловсролын хамран сургалт: 97.2 Жилийн эцэст: Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт: 90.9 Бага боловсролын хамран сургалт: 97.4 Суурь боловсролын хамран сургалт: 97.2	хамралтын хувь нь 91%д хүрч , өмнөх оныхоос 2 хувиар ахисан байна. 5 настай 2200 хүүхдээс бэлтгэлийн 60 бүлэгт 1960 хүүхэд, хувилбарт сургалт 2074 хүүхэд буюу 94 хувь нь хамрагдаж байна. Хүрсэн түвшин: 100	
1.1.2	Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр улсдаа эхний тавдугаар байрт орох зорилт тавин ажиллаж, амжилт гаргасан сум, сургууль, сурагч, бэлтгэсэн багш нарыг урамшуулан алдаршуулж, сайн туршлага, арга зүйг нийтэд дэлгэрүүлэх.	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Элсэлтийн шалгалтын аймгийн дундаж оноо	507.2	Эхний хагас жилд: 510 Жилийн эцэст: 510	Хөдөөгийн ЕБ-ын 17 сургуулийн 12 дугаар ангийн сурагчдад элсэлтийн шалгалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор эрчимжүүлсэн сургалтыг 2025 оны 4 дүгээр сарын 3-наас 7-ны өдрүүдэд Буянт ЕБС, Манхан ЕБС, Алтай ЕБС сургуулиудад 3 бүсээр зохион байгууллаа. Нийт 900 цагийн хичээлийг 36 ментор багш чиглүүллээ.Сургалтад 443 сурагч хамрагдлаа. Элсэлтийн шалгалтын	100%

						<p>эрчимжүүлсэн сургалтыг 2025.06.7-2025.06.11 өдрүүдэд Эрдэнэбүрэн, Зэрэг сумуудад амжилттай зохион байгууллаа. Сургалтанд 14 сургуулийн 283 сурагчдад 18 ментор багш сургалтыг зохион байгууллаа. Элсэлтийн шалгалтын эрчимжүүлсэн сургалтад нийт 726 сурагч хамрагдлаа. 2025-2026 оны 12 ангийн эрчимжүүлсэн сургалтыг 2025.12.22-ноос зохион байгуулахаар төлөвлөж байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ: 70.0 Хүрсэн түвшин: 100</p> <p>Хүрсэн түвшин: 507,5</p>	
1.1.3	<p>Хүүхдийн шинжлэх ухаанч, техник сэтгэлгээг хөгжүүлэх STEM төслийг сургалтын хөтөлбөртэй уялдуулан бага, дунд, ахлах ангид үе шаттай хэрэгжүүлж, хүүхдүүдийн шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математикийн мэдлэг, чадварыг дээшлүүлэхээс гадна тэдний бүтээлч чадвар, сэтгэхүйг</p>	<p>Орон нутгийн төсөв, улсын төсөв</p>	<p>STEM хэрэглэгдэхүүнд зарцуулсан санхүүжилтийн хэмжээ</p>	<p>Сургуулийн өмнөх боловсролын 339.5 сая</p>	<p>Эхний хагас жилд: Ерөнхий боловсролын сургуульд 200.0 сая Жилийн эцэст: Ерөнхий боловсролын сургуульд 200.0 сая</p>	<p>2025 онд АОНХС хөрөнгө оруулалтаар 200 сая төгрөгийн Стем хэрэглэгдэхүүний тендер зарлагдсан байна. 2025-2026 оны хичээлийн жилд 1-3 анги Стем хэрэглэгдэхүүнээр хангагдах юм. СӨБ 2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн 34 цэцэрлэгт хүүхдийн шинжлэх ухаанч, техник сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор орон нутгийн хөгжлийн сангаас 325 сая төгрөгөөр бага, дунд, ахлах , бэлтгэл бүлгийн хүүхдийг STEAM тоглоомоор хангасан. Энэхүү тоглоомыг</p>	100%

хөгжүүлэх.					<p>ашиглах арга зүйн сургалтад нийт багш нараар цахимаар 2 удаа хамруулахын зэрэгцээ бүлгийн 210 багшид гарын авлагатай болгосон. Уг гарын авлагыг бүх зардлыг STEAM боловсролын академиас санхүүжилт гаргасан. Түүнчлэн математик хариуцсан ахлах арга зүйч Батнасангай Хятадын Шанхай хотноо мэргэжил дээшлүүлсэн нь энэ тоглоомыг хэрхэн үр дүнтэй хэрэглэх боломжийг нэмэгдүүлсэн. Тухайн сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалтыг сайжруулж, хүүхэд бүрт хүргэх, эцэг эх багшийн хамтын оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч, анхдугаар уралдааныг Буянт сумын Засаг дарга, ИТХурал болон цэцэрлэгийн хамт олонтой хамтран аймгийн хэмжээнийн бэлтгэл бүлгийн 68 хүүхэд 34 багшийг оролцуулан 2025 оны 05 дугаар сарын 09 ны өдөр амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд орон нутгийн удирдлагууд сумдын цэцэрлэгийн эрхлэгч, багш нар, эцэг эхчүүдийн төлөөлөл 200 гаруй хүн оролцлоо. Боловсролын газраас арга зүйн болон зохион байгуулалтын бэлтгэл</p>	
------------	--	--	--	--	--	--

						<p>ажлыг хангахад онцгой анхаарч тухайн суманд ажлын 1-2 өдөр очиж ажилласан. Одоогоор хөтөлбөрт 5 настай 1800 хүүхэд хамрагдаж, багш нар шинэчилсэн арга зүйд суралцаж байна. /Дэлгэрэнгүй тайланг хавсаргав./ Тухайлбал улсын хэмжээний Дархан хотод 21 аймаг 9 дүүрэг оролцсон шилдэг багуудын уралдаан Жаргалант сумын 16 дугаар цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн М.Цэнд-Аюуш, Оюунсүрэн нарын удирдсан 4 хүүхэдтэй баг 4 дүгээр байр буюу тусгай байрыг эзэллээ.</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p>	
1.1.4	Уламжлалт ёс заншлаа дээдэлдэг, эх орныхоо байгаль, түүх, үндэсний хэл соёлоор бахархдаг өөртөө итгэлтэй, ёс зүйтэй, бүтээлч ирээдүйн иргэнийг төлөвшүүлэх “Эх оронч-Монгол хүүхэд” арга хэмжээг хэрэгжүүлэх.	Орон нутгийн төсөв-100.0	Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	0	Эхний хагас жилд: 50 Жилийн эцэст: 100	Засгийн газрын 2025 оны 189 дүгээр тогтоолоор 9 дүгээр сард " Чөлөөлөх дайн" 80 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан тус ойн хүрээнд 2025-2026 оны хичээлийн жилийн нээлтийн өдөр буюу 09 дүгээр сарын 01-ны эхний цагийн хичээлийг Ховд аймгийн 25 сургуулийн 193 бүлгийн 10-р ангийн 1004 сурагч, 11-р ангийн 1056 сурагч, 12- ангийн 932 сурагч нийт 2932 сурагчдад “Эх оронч Монголчууд” хичээлийг 113 багш, цэргийн	100%

					<p>ахлах офицерүүд чиглүүлэн зохион байгууллаа. Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд Монгол бахархал аяныг 25 сургууль, 34 цэцэрлэгийн дунд 5 чиглэлээр амжилттай зохион байгуулан явууллаа. Аяны хүрээнд монголын нууц товчоо зохиолоор ангилал тус бүр дээр үйл ажиллагаанууд зохион байгууллаа. Уралдаанд бага 28 бүтээл, СӨБ-22 бүтээл, дунд -47 бүтээл, ахлах-23 бүтээл ирж шилдэгүү Монгол Улсын Ерөнхийлөгийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Бидний бахархал" төслийн хүрээнд Батлан хамгаалах яамнаас Монгол Улс даяар 21 аймаг, 9 дүүргийн 16-25 насны залуучуудын хүрээнд эх оронч үзэл, үндэсний бахархлыг таниулах, мэдүүлэн төлөвшүүлэх, эх орноо хайрлан хамгаалах, цэцэглэн хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үүргийг тэргүүнд ухамсарлуулж, эх орон, тусгаар тогтнол, эх хэл, үндэсний түүх, соёлоо мэдэн бахархах, өвлөн хүндэтгэх, газар нутаг, байгаль орчноо энхийн замаар хамгаалах, итгэл үнэмшил, хариуцлагыг төлөвшүүлэх зорилготой "Эх оронч 10000" төслийг</p>
--	--	--	--	--	---

						<p>хэрэгжүүлж байна. Төслийн сургалтын үйл ажиллагаа 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 10:00 цагаас Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд зохион байгуулж сургалтад 8 сургуулийн 200 гаруй сурагчид хамрагдлаа. Төслийн сургалтын багш нар дөрвөн сэдвийн хүрээнд сурагчдад сургалт хийв. Тэд эх оронч үзэл суртал, соёл суртахууны үнэлэмжийг нэмэгдүүлэх. Үндэсний бахархлыг дархлаажуулахад иргэн бүрийн оролцоо ямар чухал талаар харилцан ярилцаж, суралцагчдын санал бодлыг сонсов. Ингэснээр хүүхэд, залуучуудын эх оронч үзэл, үндэсний тусгаар тогтнолын үнэ цэнийн талаарх мэдлэг, хандлага нэмэгдэх ач холбогдолтой</p> <p>Хүрсэн түвшин: 100</p>	
1.1.5	Хүүхэд, залуучуудын боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх тэтгэлгийн тоог нэмэгдүүлж, гадаадын их, дээд сургуульд суралцах оюутны тоог нэмэгдүүлэх арга хэмжээг санаачилж	Орон нутгийн төсөв, улсын төсөв	Тэтгэлэгт хамрагдсан сурагчдын тоо	Аймгийн тэтгэлэг-42, ерөнхийлөгчийн тэтгэлэг-10	Эхний хагас жилд: 50 Жилийн эцэст: 50	хэлтэс Аймгийн Засаг даргын 2023 оны А/504 тоот захирамжаар батлагдсан Ховд аймгийн Засаг даргын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журмын дагуу МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуулийн суралцагчдад 2024-2025 оны хичээлийн жилд бакалаврын өдрийн	100%

	хэрэгжүүлэх					<p>ангид 550 болон түүнээс дээш оноотой элссэн, математик, хими, физик, гадаад хэл, монгол хэл, бага ангийн багш мэргэжлээр 2.8 болон түүнээс дээш голч оноотой суралцаж буй 40 оюутныг шалгаруулж 40 сая төгрөгийн тэтгэлэг олгуулж ажилласан байна. 2025-2026 оны хичээлийн жилд 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/898 тоот захирамжаар Аймгийн Засаг даргын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журмыг шинэчлэн баталсан. Тухайн захирамжийг шинэчлэн батлахад санал өгч ажилласан. Захирамжийн дагуу 12 дугаар сард багтаан тэтгэлэгийг олгохоор ажиллаж байна. Мөн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд хөшөөт хөгжил сан, ховд эко цемент, халзан бүрэгтэй ХХК, банк санхүүгийн байгууллагуудаас зарлагдсан тэтгэлэгт хөтөлбөрт 56 оюутан хамрагдсан байна.</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p>	
1.2.	Бүх шатны боловсролын сургалтын байгууллагад цахим орчныг бүрдүүлнэ	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Шаардлага хангасан сургалтын цахим орчин бүрдүүлсэн сургалтын байгууллагын тоо	6	25	<p>БЯ, БЕГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу Ховд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн 25 сургуулийн</p>	100%

						захирлуудаас санал асуулгаар Mobicom, Unitel, G-Mobile, Монголын цахилгаан холбоо интернэт үйлчилгээ үзүүлэгч компаниудаас сонгох саналыг Google Form-оор санал асуулга зохион байгуулахад 17 сургууль буюу 71% нь Unitel компаныг сонгосноор 2025 оны 02 дугаар сарын 28-ны дотор бүх сургуулиуд гэрээ хийж, 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн интернэт үйлчилгээг авч эхэлсэн. Нийт 24 сургууль сарын 29,029,000.00 төгрөгийн төлбөр төлөх гэрээ хийгдсэн. Улсын төсвийн болон орон нутгийн санхүүжилтээр цахим тоног төхөөрөмж худалдан авах үйл ажиллагаа явагдаагүй	
1.2.1	Бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг цахим хэрэглээнд бүрэн шилжүүлж, цахим орчныг бүрдүүлэн, цахимжсан боловсролыг чанартай эзэмшүүлэх нөхцөлийг хангах	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Шаардлага хангасан цахим ангийн тоо	47	Эхний хагас жилд: 60 Жилийн эцэст: 70	БЯ, БЕГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу Ховд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн 25 сургуулийн захирлуудаас санал асуулгаар Mobicom, Unitel, G-Mobile, Монголын цахилгаан холбоо интернэт үйлчилгээ үзүүлэгч компаниудаас сонгох саналыг Google Form-оор санал асуулга зохион байгуулахад 17 сургууль буюу 71% нь Unitel компаныг сонгосноор 2025 оны 02	100%

						<p>дугаар сарын 28-ны дотор бүх сургуулиуд гэрээ хийж, 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн интернэт үйлчилгээг авч эхэлсэн. Нийт 24 сургууль сарын 29,029,000.00 төгрөгийн төлбөр төлөх гэрээ хийгдсэн. Улсын төсвийн болон орон нутгийн санхүүжилтээр цахим тоног төхөөрөмж худалдан авах үйл ажиллагаа явагдаагүй.</p> <p>Хүрсэн түвшин: Сургууль цэцэрлэгүүд цахим үйлчилгээний зардлаас удирдах болон үйлчилгээний албан хаагчдад компьютер, тоног төхөөрөмж худалдан авсан.</p>	
1.2.2	<p>Математик, англи хэлний мэдлэг, чадвар олгох Eduten, Pearson болон бусад цахим платформуудын ашиглалтыг сайжруулж, суралцагчдын математик, англи хэлний мэдлэгийг гүнзгийрүүлж, боловсролын ялгаатай байдлыг арилгах.</p>	Улсын төсөв	Цахим платформуор суралцагчдын тоо	Бага ангийн 8033 сурагч	<p>Эхний хагас жилд: Бага ангийн 10159 Жилийн эцэст: Бага ангийн 10159</p>	<p>Бага ангийн математикийн сургалтын чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх eduten цахим хөтөлбөрийн хүрээнд аймгийн 24 сургуулийн бага ангид eduten сургалтын цахим анги байгуулан ажиллаж байна. I-Ү ангиуд хичээлийн хуваарийн дагуу цахим ангид хичээллэж, дасгал даалгавар ажилласнаар бага ангийн математикийн сургалтын чанар 1,8 хувиар ахисан байна. Eduten цахим</p>	100%

						<p>хөтөлбөрийг яаж математикийн сургалтын хөтөлбөрт дэмжлэг үзүүлэн, аль агуулгыг давтахад яаж ашиглах талаар 322 багшийг ахисан түвшний сургалтад хамрууллаа. Мөн БЕГ-тай хамтран eduten хичээл заахад тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар цахим уулзалт зохион байгуулж багш нарт зөвлөгөө өглөө. БЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2024-2025 оны хичээлийн жилд олон улсын англи хэлний “Pearson хөтөлбөр”-ийг 3-4 дүгээр анги туршин хэрэгжүүлж буй явцыг үнэлэх, тулгарч буй асуудлуудыг тодорхойлох, цаашид анхаарах асуудлыг дүгнэх зорилгоор хяналт үнэлгээ, зөвлөн туслах үйл ажиллагааг 03 дугаар сарын 12,13, 20-ны өдрүүдэд зохион байгуулж ажиллалаа. Жаргалант 1, Цаст-Алтай, Мянгад сургуулийн хэрэгжилттэй танилцаж, 5 удирдлага, 16 багштай ярилцлага хийн, 4 багшийн хичээлд ажиглалт хийж зөвлөгөө өглөө. Мөн 19 багш, 6 удирдлагаас асуулга судалгаа авлаа. Англи хэлний Пийрсон хөтөлбөрийн хүрээнд 2025-2026 оны хичээлийн жилд 3,4 дүгээр</p>
--	--	--	--	--	--	---

						<p>ангид дэвших бүлгийн тоо, ЕБС-ийн англи хэлний багшийн судалгааг 25 сургуулиас авч нэгтгэн БЕГ-т хүргэв. PEARSON хөтөлбөрийн номыг сургуулиудад хүлээлгэн өглөө. 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн улсын хэмжээнд төрийн өмчийн бүх ЕБС-ийн 3, 4 дүгээр ангийн сурагчдад англи хэлний хичээл орж эхлэхтэй холбогдуулан багш нарыг чадавхжуулах сургалт 08 дугаар сарын 26,27-ны өдөр зохион байгуулагдаж 44 багш хамрагдлаа. Pearson хөтөлбөрт 24 сургуулийн 106 багш, 3-8-р ангийн 11998, туршилтын сургуулийн 9-12-р ангийн 683, нийт 12681 сурагч хамрагдаж байна.</p> <p>Хүрсэн түвшин: 100</p>	
1.3.	Багшийн мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжинэ	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Орон нутгийн сургалтад хамрагдсан багшийн тоо	130	430	<p>Багш нарыг чадавхжуулах 12 судлагдахууны 1051 багшийн сургалтыг 9-12 сард зохион байгуулахаас Хими, Биологи, Физик, Математик, Монгол хэл, Нийгэм, Түүх, Газар зүйн судлагдахууны сургалтыг зохион байгууллаа. Нийт 8 судлагдахууны 424 багшийг сургалтанд хамрууллаа. Үлдсэн 4 судлагдахууны 627 багшийн сургалтыг 12 сард зохион байгуулахаар</p>	100%

						төлөвлөж байна. Англи хэлний IELTS-ийн сургалтанд 20 багш, Мөн ОХУ-ын Горний алтай хотын зуны сургалтанд 15 багш хамрагдлаа.	
1.3.1	Багш нарыг чадавхжуулах сургалтад цэцэрлэгийн 75, бага ангийн 87 дунд, ахлах ангийн 225, англи хэлний 32, МСҮТ-ийн 20 багшийг үе шаттайгаар хамруулж, багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлж, боловсролын чанарыг сайжруулах.	Орон нутгийн төсөв	Орон нутгийн сургалтад хамрагдсан багшийн тоо	130	Эхний хагас жилд: 200 Жилийн эцэст: 400	Багш нарыг чадавхжуулах 12 судлагдахууны 1051 багшийн сургалтыг 9-12 сард зохион байгуулахаас Хими, Биологи, Физик, Математик, Монгол хэл, Нийгэм, Түүх, Газар зүйн судлагдахууны сургалтыг зохион байгууллаа. Нийт 8 судлагдахууны 424 багшийг сургалтанд хамрууллаа. Үлдсэн 4 судлагдахууны 627 багшийн сургалтыг 12 сард зохион байгуулахаар төлөвлөж байна. Англи хэлний IELTS-ийн сургалтанд 20 багш, Мөн ОХУ-ын Горний алтай хотын зуны сургалтанд 15 багш хамрагдлаа. Хүрсэн түвшин: 100%	100%
1.3.2	Багшийн нарийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлэн сургалтын чанарыг сайжруулж, хүүхдүүдийн боловсролд эерэг өөрчлөлтийг бодитоор бий болгох зорилгоор	Орон нутгийн төсөв	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хувь	0	Эхний хагас жилд: 10 Жилийн эцэст: 25	Ховдын ирээдүй хөтөлбөрийг аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж байна “Ховдын ирээдүй” төсөл арга хэмжээний хүрээнд ахлах, дунд ангийн 5, бага ангийн 5, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 3, мэргэжлийн боловсролын байгууллагын 1, их сургуулийн 1 багш, нийт 15 багшийг орон сууцны урьдчилгаатай дүйцэхүйц	100%

	“Чадварлаг багш” төслийг хэрэгжүүлэх					хэмжээний /30 сая/ мөнгөн дүн нийт 450 сая төгрөгөөр урамшууллаа. урамшуулсан.Мөн Шилдэг менежменттэй сургууль, Шилдэг дотуур байр, Шилдэг мэргэжлийн бүлэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хүрсэн түвшин: 100	
1.4.	МУИС-ийн Баруун бүсийн сургууль, мэргэжлийн боловсролын Хөгжил политехник коллежид хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн шинэ ангиудыг нээж, сургалтын хөтөлбөрийг шинэчилнэ	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Шинээр нээгдсэн нарийн мэргэжлийн ангийн тоо, шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн тоо	0	3	МУИС-ийн баруун бүсийн сургууль нь орон нутагт эрэлт хэрэгцээтэй бакалаврын 30, магистрын 12, докторын 6 мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж байна. Хөгжил политехник коллеж нь 2023 онд мэдээлэл технологийн шинэ анги, хосмог мэргэжлээр барилгын техник технологийн ангийг тус тус нээн элсэлтийг тогтмол авч байна.	100%
1.4.1	Техник мэргэжлийн сургуульд хосмог мэргэжил эзэмших хөтөлбөрүүдийг дэмжинэ	Батлагдсан төсөв	Хэрэгжүүлсэн хөтөлбөрийн тоо	0	Эхний хагас жилд: 0 Жилийн эцэст: 1	Автомашин засвар, үйлчилгээний анги нээхээр судалгаа хийсэн хөтөлбөр боловсруулах шатанд ажиллаж байна. Хүрсэн түвшин: 100%	100%
1.5.	ЕБС, дотуур байр, СӨБ-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг	Орон нутгийн төсөв, улсын төсөв	Стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн орчин бүрдүүлсэн сургалтын	Сургууль-16, цэцэрлэг-30, дотуур байр-15	Сургууль-25, цэцэрлэг-34, дотуур байр-17	Ерөнхий боловсролын 24 сургууль үдийн хоол хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлж байна. Түрээсийн гэрээг бүрэн	100%

сайжруулна.		байгууллагын тоо			<p>цуцалсан. ОНХС хөрөнгө оруулалтаар 70,0 сая төгрөгөөр хоол, үйлдвэрлэлийн 9 нэр төрлийн 38ш тоног төхөөрөмж хүлээн авсан Боловсролын дэлхийн түншлэл (GRE)-төслийн санхүүжилтээр 35,2 сая төгрөгийн аяга таваг угаагч автомат машиныг 4 сургуульд, гал тогооны 32 нэр төрлийн тоног төхөөрөмжийг тус төсөлд хамрагдсан 3 сургуульд хүлээлгэн өгсөн. ЕБ-ын 24 сургууль, 18 дотуур байр, 34 цэцэрлэг өнгөний системийг гэр зөвлөмжтэй уялдуулан нэгдсэн жишиг цэс боловсруулан мөрдлөг болгон ашиглаж байна. Жишиг цэс боловсруулах ажилд ЕБС, дотуур байр, СӨББ-н хоол зүйч, ахлах тогооч, эмч нийт 20 хүнийг оролцуулан хэлэлцүүлэг хийж цэс боловсруулав.. Цэцэрлэгт 73, туслах ажилтан 21, ЕБС-ийн үдийн хоолонд 54 тогооч, туслах ажилтан 30, Дотуур байрын 39 тогооч, туслах ажилтан 18, нийт 229 хүн ажиллаж байна. Хүнсний хангамж, нөөцийг тендерт шалгарсан аж ахуйн нэгжээс авч, стандартын дагуу хоол үйлдвэрлэл үйлчилгээг</p>
-------------	--	------------------	--	--	--

						<p>хэрэгжүүлж байна. Тендер амжилттай 19 , дэлгүүрээс 6 ЕБС худалдан авалт хийж байна.2025 онд ерөнхий боловсролын 21 сургууль ОНХС, эцэг эхийн дэмжлэгтэйгээр ахлах, дунд ангийн 8250 гаруй сурагч үдийн хоолонд хамрагдсанаас 9 сургууль ARTA системийг ашиглан мэдээлэл болон карт нээж төлбөр тооцоонд ашиглаж байна. Дарви сумын ЕБС-ийн ахлах дунд ангийн 340 хүүхдийн хоолны зардал 41 сая төгрөгийн санхүүжилтийг ОНХСангаас шийдвэрлэсэн, Цэцэг сумын ЕБС-ийн 363 сурагчийн хоолны зардлын 25%-ийг ОНХС, 75%-ийг эцэг эх асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэсэн байна. 2025оны 11сард Жаргалант сумын 7 сургуулийн 7 хоол зүйч, 7 тогоочийг туршлага солилцох уулзалт зохион байгуулж 1-р сургуулийн гал тогоонд төрөл бүрийн салат, үндсэн хоол хийж бие биенээсээ суралцсан арга барилаа хуваалцсан арга хэмжээ боллоо.</p>	
1.5.1	Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны гал тогоог	Орон нутгийн төсөв-100.0	Стандартын шаардлага хангасан хоолны газартай цэцэрлэгийн хувь	40%	Эхний хагас жилд: 50% Жилийн эцэст: 60%	Ерөнхий боловсролын 24 сургуульд 10157 сурагч, сургуулийн өмнөх боловсролын 34	100%

	<p>чанартай, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн орчинд үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлэх</p>					<p>байгууллагад 7272 хүүхэд суралцаж байна. Сургуульд хоол үйлдвэрлэлийн 127 , цэцэрлэгт 69 тогооч, хоол үйлдвэрлэл үйлчилгээний ажилчид ажиллаж байна. 2025 оны 2 дугаар сард орон нутгийн төсвөөс 70 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлэн гал тогооны 6 багц тоног төхөөрөмжийг ЕБС, СӨББ-д хүлээлгэн өгсөн. Боловсролын дэлхийн түншлэл (GPE) төсөлд Прогресс, Минжит булган, Дарви сумын сургуулиуд хамрагдаж 32 төрлийн багц төхөөрөмж хүлээн авна. Булган1, Цэцэг сумын сургууль, Жаргалант 2-р сургуульд автомат аяга таваг угаагч хүлээн авсан байна. Ерөнхий боловсролын сургууль -3, цэцэрлэг- 2 нөхөн хангалтын зардлаас гал тогооны тоног төхөөрөмж, туслах хэрэгсэл, ширээ сандалд зориулж нийт- 89 сая төгрөг зарцуулсан байна. Алтай сумын сургуулийн гал тогооны засвар 10 сая, Буянт сумын сургууль цахилгааны ба гал тогооны засварыг ОНХСангаас 79 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлэн хийлгэсэн. Ингэснээр нийт сургуулийн 80% нь тоног төхөөрөмжөөр</p>	
--	--	--	--	--	--	---	--

						<p>хангагдаад байна. 2025 онд орчин үеийн ариун цэврийн байгууламжид 100% холбогдсоноор 25 сургууль, 34 цэцэрлэг төвлөрсөн усан хангамжтэй боллоо.. Орон нутгийн хөгжлийн сангийн төсвөөс санхүүжүүлэн Прогресс сургууль 280 сая төгрөгийн төсөвтэй гал тогоо болон төвлөрсөн усан хангамжид бүрэн засварын ажил хийгдсэн. Стандартын шаардлага хангасан гал тогоотой сургууль 22 буюу 76%, цэцэрлэг 28 буюу 76% эзэлж байна. Ахлах, дунд ангийн сурагчдыг үдийн хоолонд хамруулах ажлыг зохион байгуулж 22 сургуулийн 8500 гаруй сурагчид үдийн хоолонд хамрагдаж байна. 9 сургууль 49500000 төгрөгөөр ARTA системийн киоск машин авч ХҮҮ-нд ашиглаж байна.</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p>	
1.5.2	<p>Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг үдийн хоол хөтөлбөрт үе шаттайгаар хамруулж, хоолны шим тэжээлийг сайжруулан, сурагчдын эрүүл</p>	Орон нутгийн төсөв	Стандартын шаардлага хангасан хоолны газартай сургуулийн хувь	16	<p>Эхний хагас жилд: 50 Жилийн эцэст: 100</p>	<p>Ерөнхий боловсролын 24 сургууль үдийн хоол хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлж байна. Түрээсийн гэрээг бүрэн цуцалсан. ОНХС хөрөнгө оруулалтаар 70,0 сая төгрөгөөр хоол, үйлдвэрлэлийн 9 нэр төрлийн 38ш тоног</p>	100%

	<p>мэнд, өсөлт, хөгжилд эерэг нөлөө үзүүлэх боломж бүрдүүлэх</p>				<p>төхөөрөмж хүлээн авсан Боловсролын дэлхийн түншлэл (GPE)-төслийн санхүүжилтээр 35,2 сая төгрөгийн аяга таваг угаагч автомат машиныг 4 сургуульд, гал тогооны 32 нэр төрлийн тоног төхөөрөмжийг тус төсөлд хамрагдсан 3 сургуульд хүлээлгэн өгсөн. ЕБ-ын 24 сургууль, 18 дотуур байр, 34 цэцэрлэг өнгөний системийг гэр зөвлөмжтэй уялдуулан нэгдсэн жишиг цэс боловсруулан мөрдлөг болгон ашиглаж байна. Жишиг цэс боловсруулах ажилд ЕБС, дотуур байр, СӨББ-н хоол зүйч, ахлах тогооч, эмч нийт 20 хүнийг оролцуулан хэлэлцүүлэг хийж цэс боловсруулав.. Цэцэрлэгт 73, туслах ажилтан 21, ЕБС-ийн үдийн хоолонд 54 тогооч, туслах ажилтан 30, Дотуур байрын 39 тогооч, туслах ажилтан 18, нийт 229 хүн ажиллаж байна. Хүнсний хангамж, нөөцийг тендерт шалгарсан аж ахуйн нэгжээс авч, стандартын дагуу хоол үйлдвэрлэл үйлчилгээг хэрэгжүүлж байна. Тендер амжилттай 19 , дэлгүүрээс 6 ЕБС худалдан авалт хийж байна.2025 онд ерөнхий боловсролын 21 сургууль</p>	
--	--	--	--	--	--	--

						<p>ОНХС, эцэг эхийн дэмжлэгтэйгээр ахлах, дунд ангийн 8250 гаруй сурагч үдийн хоолонд хамрагдсанаас 9 сургууль ARTA системийг ашиглан мэдээлэл болон карт нээж төлбөр тооцоонд ашиглаж байна. Дарви сумын ЕБС-ийн ахлах дунд ангийн 340 хүүхдийн хоолны зардал 41 сая төгрөгийн санхүүжилтийг ОНХСангаас шийдвэрлэсэн, Цэцэг сумын ЕБС-ийн 363 сурагчийн хоолны зардлын 25%-ийг ОНХС, 75%-ийг эцэг эх асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэсэн байна. 2025оны 11сард Жаргалант сумын 7 сургуулийн 7 хоол зүйч, 7 тогоочийг туршлага солилцох уулзалт зохион байгуулж 1-р сургуулийн гал тогоонд төрөл бүрийн салат, үндсэн хоол хийж бие биенээсээ суралцсан арга барилаа хуваалцсан арга хэмжээ боллоо.</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p>	
1.6.	Боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлж, сургалтын орчин,	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Боловсролын байгууллагын хөрөнгө оруулалтын хэмжээ	сая төгрөг	сая төгрөг	<p>Аймгийн ИТХ 2 дугаар тогтоолоор "Ховдын ирээдүй" төсөл арга хэмжээ 2 тэрбум төгрөгөөр батлагдаж хэрэгжиж эхэллээ. Үүний хүрээнд бага боловсролын хөтөлбөрийн</p>	100%

	чанар, хүртээмжийг сайжруулж, сурагчдад орчин үеийн боловсролыг хүртэх боломжийг бүрдүүлнэ.					шинэчлэлийн хүрээнд 220 сая төгрөгийн 1-3 ангийн Стем тоглоом, сургууль цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг 70 сая төгрөгөөр тус бүр тендер зарлаж гүйцэтгэгч компани нийлүүлээд байна. сургалтын байгууллагын санал хүсэлтэд үндэслэн хуваарилалтыг хийж байна.	
1.6.1	СӨБ-ын байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандартын шаардлага хангасан орчинг бүрдүүлэх	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Засвар хийгдсэн болон шинээр баригдсан цэцэрлэгийн тоо	орон нутгийн төсөв- 9 цэцэрлэг засвар, ариун цэврийн байгууламж 13 цэцэрлэг	Эхний хагас жилд: орон нутгийн төсөв- 9 цэцэрлэг засвар, ариун цэврийн байгууламж- 14 цэцэрлэг Жилийн орон нутгийн төсөв- 9 цэцэрлэг засвар, ариун цэврийн байгууламж- 16 цэцэрлэг	2025 онд Аймгийн ОНХС хөрөнгө оруулалтаар 9 цэцэрлэгийн иж бүрэн болон хэсэгчилсэн засварын ажил батлагдсанаас 8 цэцэрлэгийн 1,4 тэрбум төгрөгийн засварын ажил гэрээний хугацаандаа хийгдэж комисс хүлээн авлаа.Үүнд: Жаргалант 7-р цэцэрлэг, Дөргөн сумын цэцэрлэг, Жаргалант 12-р цэцэрлэг, Жаргалант 11-р цэцэрлэг, Жаргалант 15-р цэцэрлэг, Жаргалант 16-р цэцэрлэг, Жаргалант 1-р цэцэрлэг, Жаргалант 5-р цэцэрлэгүүдэд барилгын засварын ажлууд амжилттай хийгдлээ. Хүрсэн түвшин: 100%	100%
1.6.2	ЕБС-ийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандартын	Улсын төсөв, орон нутгийн	Засвар хийгдсэн болон шинээр баригдсан	орон нутгийн төсөв- 10 сургууль засвар,	Эхний хагас жилд: орон нутгийн төсөв- 12	2025 онд Аймгийн ОНХС хөрөнгө оруулалтаар 8 сургуулийн иж бүрэн болон хэсэгчилсэн засварын ажил	100%

	шаардлага хангасан орчинг бүрдүүлэх	төсөв	сургуулийн тоо	ариун цэврийн байгууламж-15 сургууль	сургууль засвар, ариун цэврийн байгууламж-16 сургууль Жилийн эцэст: орон нутгийн төсөв-14 сургууль засвар, ариун цэврийн байгууламж-17 сургууль	батлагдсанаас 4 сургуулийн 1,2 тэрбум төгрөгийн засварын ажил гэрээний хугацаандаа хийгдэж комисс хүлээн авлаа.Үүнд: Жаргалант 1-р сургууль, Прогресс сургууль, Мөст сумын бага сургууль, Жаргалант 3-р сургуулиудын барилгын засварын ажлууд юм. Мөн төсвийн тодотголоор хасагдсан 4 сургууль буюу Булган 1-р сургууль, Алтай сумын сургууль, Эрдэнэбүрэн сургууль, Жаргалант 2-р сургуулийн спорт заалны засварууд гэрээ хийгдэж амжаагүй тул 2026 онд хэрэгжихээр боллоо. Хүрсэн түвшин: 100%	
1.6.3	Ерөнхий боловсролын сургуулиудын номын сангийн фонд баяжилтыг шаттайгаар нэмэгдүүлэх үе	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Танин мэдэхүй, шинжлэх ухаан, гадаад, дотоодын уран зохиолын номоор сургуулийн фондын баяжилт хийсэн сургуулийн тоо	0	Эхний хагас жилд: 12 Жилийн эцэст: 25	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 40,0 сая төгрөгийн Дэлхийн шилдэг 1-12 дугаар ангийн уран зохиолын номыг Жаргалант сумын ерөнхий боловсролын 7 сургуульд 50%-ийн гүйцэтгэлтэй олгож номын сангийн баяжилтыг хийсэн байна. Үлдэгдэл 70,0 сая төгрөг номыг 2025 оны 12 дугаар сард нийлүүлнэ. Хүрсэн түвшин: 90%	90%
1.7.	Багш нарыг	Улсын	Багшийн нийгмийн	2,8	3.10	Ховд аймгийн засаг даргын	100%

	<p>тогтвортой ажиллах нөхцөл боломжоор хангаж, тэдний болон суралцагчдын нийгмийн баталгааг сайжруулж, боловсролын түншлэлийг нэмэгдүүлнэ</p>	<p>төсөв, орон нутгийн төсөв</p>	<p>баталгааг хангах чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, боловсролын түншлэлийн тоо</p>			<p>мөрийн хөтөлбөрт тусгагдсанаар боловсролын салбарт 2025-2028 онд хэрэгжүүлэх "Ховдын ирээдүй" төсөл арга хэмжээнд багшийн хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг хангах, урамшуулах чиглэлээр 870 гаруй сая төгрөгийг тусгасан. "Ховдын ирээдүй" төсөл арга хэмжээний урамшууллын журмыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр засаг даргын зөвлөлөөр эцэслэн батлуулсан урамшууллын журмын дагуу шилдэг багш, элсэлтийн шалгалтад амжилт үзүүлсэн багш, мэргэжлийн хөгжлийн бүлгээр хамтран ажилласан багш, анги нийтийн олимпиадад амжилттай бэлтгэсэн багш зэрэг шаогаруулалтуудаар шалгаруулан урамшуулсан. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, их сургууль, мэргэжлийн боловсролын сургууль гэсэн салбар бүрээс шилдэг 15 багш шалгаруулан тус бүрийг байрны урьдчилгаатай дүйцэх 30 сая төгрөгийн урамшуулал олгосон. Элсэлтийн шалгалтад бэлтгэсэн сурагчдын амжилтыг үнэлэн 96 багшийг</p>	
--	---	----------------------------------	--	--	--	--	--

						102,000,000 төгрөгөөр урамшуулсан. багш бүр амжилтаас хамааран 11,000-7,300,000 төгрөгийн урамшуулал хүртсэн. Тухайн төсөл арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан элсэлтийн шалгалтын эрчимжүүлсэн сургалтад ментор багшаар ажилласан 45 багшид нийт 70 гаруй сая төгрөгийн урамшуулал олгоод байна. Улс бүсийн олимпиад болон элсэлтийн шалгалтад амжилт үзүүлсэн 43 сурагчид 52 сая төгрөгийн урамшуулаллыг Ховдын ирээдүй төсөл арга хэмжээнээс олгосон.	
1.7.1	Багш, удирдах ажилтан, арга зүйчид, үйлчилгээний ажилчдын хөдөлмөрийн бүтээмжийг үнэлж, урамшуулснаар ажлын үр дүнг нэмэгдүүлж, тэдний сэтгэл ханамж, нийгмийн баталгааг сайжруулах	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Багшийн нийгмийн баталгааг хангахад орон нутгаас зарцуулсан төсвийн хэмжээ	107.5 сая төгрөг	Эхний хагас жилд: 250 сая төгрөг Жилийн эцэст: 500 сая төгрөг	Ховд аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсанаар боловсролын салбарт 2025-2028 онд хэрэгжүүлэх "Ховдын ирээдүй" төсөл арга хэмжээнд багшийн хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг хангах, урамшуулах чиглэлээр 870 гаруй сая төгрөгийг тусгасан. "Ховдын ирээдүй" төсөл арга хэмжээний урамшууллын журмыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр засаг даргын зөвлөлөөр эцэслэн батлуулсан урамшууллын журмын дагуу шилдэг багш, элсэлтийн шалгалтад	100%

						<p>амжилт үзүүлсэн багш, мэргэжлийн хөгжлийн бүлгээр хамтран ажилласан багш, анги нийтийн олимпиадад амжилттай бэлтгэсэн багш зэрэг шаогаруулалтуудаар шалгаруулан урамшуулсан. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллага, их сургууль, мэргэжлийн боловсролын сургууль гэсэн салбар бүрээс шилдэг 15 багш шалгаруулан тус бүрийг байрны урьдчилгаатай дүйцэх 30 сая төгрөгийн урамшуулал олгосон. Элсэлтийн шалгалтад бэлтгэсэн сурагчдын амжилтыг үнэлэн 96 багшийг 102,000,000 төгрөгөөр урамшуулсан. багш бүр амжилтаас хамааран 11,000-7,300,000 төгрөгийн урамшуулал хүртсэн. Тухайн төсөл арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан элсэлтийн шалгалтын эрчимжүүлсэн сургалтад ментор багшаар ажилласан 45 багшид нийт 70 гаруй сая төгрөгийн урамшуулал олгоод байна.</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p>	
1.7.2	Хувийн хэвшлийн цэцэрлэг, сургууль,	Орон нутгийн	Шинээр үйл ажиллагаа эрхэлж	Цэцэрлэг-4, сургууль-0	Эхний хагас жилд:	Ховд аймагт хувийн хэвшлийн 4 цэцэрлэг үйл	90%

	сургалтын байгууллага байгуулах санал, санаачилгыг дэмжих	төсөв	буй хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэгийн тоо		Цэцэрлэг-4, сургууль-2 Жилийн эцэст: Цэцэрлэг-4, сургууль-2	ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2025 оны эхний хагас жилд шинээр сургууль, цэцэрлэг байгуулах санал, албан хүсэлт ирээгүй. Бялзуухай цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан байсныг холбогдох баримт бичгийн бүрдлийг үндэслэн сунгах шийдвэр гаргасан. Хүрсэн түвшин: 90%	
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
3.1.	Боловсролын ерөнхий хууль, түүнийг хэрэгжүүлэхээр даган гарсан журмуудыг хэрэгжүүлнэ	Үйл ажиллагааны зардал	Журмын дагуу нөхөн олгосон боловсролын бичиг баримтын тоо	45	45	ЗГ-ын тогтоол, сайдын тушаал, тэдгээрт нийцүүлэн гаргасан зөвлөмж чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Боловсролын сайдын тушаал 2, чиглэл 3 албан даалгавар 3, Боловсролын яамны чиглэл 1, Аймгийн засаг даргын 4 захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд нэгж байгууллагад чиглэл, зөвлөмж гарган хүргүүлж ажилласан. Мөн ЗГ 2024 оны цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоол №238, хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэх тухай тогтоол №254, Боловсролын сайдын зардлын заавар батлах тухай 2024 оны А/279 тушаал, Багш ажилтны	100%

					<p>цалин нийгмийн баталгааг хангахтай холбоотой, туслах багш ажиллуулах чиглэлүүдийг нэгж байгууллагуудад хүргүүлэн танилцуулга мэдээллээр хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж байна. ЗГ 2024 оны цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоол №238, хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэх тухай тогтоол №254, Боловсролын сайдын зардлын заавар батлах тухай 2024 оны А/279 тушаал, Багш ажилтны цалин нийгмийн баталгааг хангахтай холбоотой, туслах багш ажиллуулах чиглэлүүдийг нэгж байгууллагуудад хүргүүлэн танилцуулга мэдээллээр хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж байна. Боловсролын сайдын 2024 оны А/279 зардлын заавар батлах тухай тушаалаар баталсан ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын “Хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулах тайлагнах” заавар аргачлал, 2025 оны төсвийг хэрэгжүүлэх чиглэлийг нийт захирал, эрхлэгч нарт танхимаар мэдээлэл өгч</p>
--	--	--	--	--	--

						ажиллав. Мөн санхүүгийн ажилтануудад дээрх сэдвээр цахим байдлаар танилцуулга бэлдэж мэдээлэл өгөв. Мөн төсвийн тодотголтой холбоотой чиглэл, Сайдын унаа хоолны хөнгөлөлт, ажил хаялтын үеийн нөхөн олговор зэрэг цаг үеийн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн арга зүйгаар ханган ажиллав.	
3.1.1	ЗГ-ын тогтоол, сайдын тушаал, тэдгээрт нийцүүлэн гаргасан зөвлөмж чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх	Улсын төсөв	Хяналтанд авсан тогтоол, тушаал, шийдвэр, зөвлөмжийн тоо	13	Эхний хагас жилд: 15 Жилийн эцэст: 20	ЗГ-ын тогтоол, сайдын тушаал, тэдгээрт нийцүүлэн гаргасан зөвлөмж чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Боловсролын сайдын тушаал 2, чиглэл 3 албан даалгавар 3, Боловсролын яамны чиглэл 1, Аймгийн засаг даргын 4 захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд нэгж байгууллагад чиглэл, зөвлөмж гарган хүргүүлж ажилласан. Мөн ЗГ 2024 оны цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоол №238, хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэх тухай тогтоол №254, Боловсролын сайдын зардлын заавар батлах тухай 2024 оны А/279 тушаал, Багш ажилтны цалин нийгмийн баталгааг хангахтай холбоотой, туслах багш ажиллуулах	100%

						чиглэлүүдийг нэгж байгууллагуудад хүргүүлэн танилцуулга мэдээллээр хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж байна. Хүрсэн түвшин: 100%	
3.1.2	Боловсролын хууль тогтоомж, бодлого шийдвэрийг иргэд олон нийтэд таниулах, сурталчлах, хэрэгжилтийг хангах, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах	Улсын төсөв	Зохион байгуулсан ажлын тоо, оролцогчийн тоо	2 арга хэмжээ 200 хүн	Эхний хагас жилд: 2 арга хэмжээ 300 хүн Жилийн эцэст: 4 арга хэмжээ 400 хүн	2025 оны эхний хагас жилд хяналтад 3 тогтоол, 7 тушаал, 5 шийдвэр, 8 зөвлөмжийг хяналтад авч нэгж байгууллагуудад зөвлөмж, чиглэл болгон хүргүүлсэн. Хүрсэн түвшин: 100%	100%
3.1.3	Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед сургалтын үйл ажиллагааг тасалдуулалгүй зохион байгуулах	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	Эхний хагас жилд: 2 Жилийн эцэст: 2	Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг 25 сургууль, 34 цэцэрлэг гарган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчний дэгдэлт ихэссэн тул ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын хичээл сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй 2025 оны 1 дүгээр сард 7 хоногийн хугацаанд цахим сургалтад шилжүүлэн ажиллав. Орон даяар өрнөсөн багш нарын ажил хаялтад Ховд аймгийн 11 сургуулийн 892 багш нэгдэж 9812 сурагч 2-12 өдрийн хичээлийн хоцрогдол	100%

						<p>үүсээд байгааг БЯ, БЕГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу хичээлийн жилд багтаан агуулгаар нөхөх үүрэг даалгаврыг ажил хаялтад нэгдсэн ЕБС-ын захирлуудад хүргэсэн. 2025 оны 11 сарын дунд үеэс дэгдээд байгаа томуу, томуу төст өвчний дэгдэлтийн судалгааг ЭМГ-аас авах, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн ирцийг өдөр өдрөөр авах байдлаар тандалт хийн ажиллаж байна. Шаардлагатай тохиолдолд сургалтын үйл ажиллагааг цахимд шилжүүлэх бэлтгэлийг хангаад байна.</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p>	
3.1.4	Төгсөгчдөд боловсролын баримт бичиг олгох	Үйл ажиллагааны зардал	Төгсөгчдийн тоо	0	Эхний хагас жилд: 110 Жилийн эцэст: 1360	<p>хэлтэс Ховд аймгийн ерөнхий боловсролын 25 сургуулийн 9 дүгээр ангийн 1613 төгсөгчдөд суурь боловсролын гэрчилгээ, 12 дугаар ангийн 1200 төгсөгчдөд бүрэн дунд боловсролын үнэмлэхийг 2025 оны 06 дугаар сард олгосон. Боловсролын баримт бичгийг сургуулиудын сонгосон хувийн ЛМС-с хэвлэсэн.</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p>	100%
3.1.5	Орон нутгийн хөгжлийн бодлого,	Батлагдсан төөв	Төрөлжсөн сургалттай	0	Эхний хагас жилд: 0	<p>Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын</p>	100%

	<p>төлөвлөлт, хүн амын нягтаршил, газар зүйн байршил зэрэг хүчин зүйлийг харгалзан ахлах сургууль байгуулах, төрөлжүүлэх ажлыг зохион байгуулах</p>		сургуулийн тоо		<p>Жилийн эцэст: 2</p>	<p>сургуулийн ахлах ангийн суралцагчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор математик, мэдээллийн технологийн чиглэлээр төрөлжсөн хөтөлбөрөөр хичээллүүлэх чиглэлээр Боловсролын ерөнхий газар, "Интерактив" ХХК-ын захирал Б.Ууганбаяр нартай зөвшилцөн тохиролцож, төлөвлөгөө боловсруулах шатанд явагдаж байна.</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p>	
3.1.6	<p>Сургалтын байгууллагын багш, ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.</p>	Батлагдсан төсөв	<p>Үзлэгт хамрагдсан багш, ажилчдын тоо</p>	ЕБС-974, СӨБ-560	<p>Эхний хагас жилд: ЕБС-1592, СӨБ-710 Жилийн эцэст: ЕБС-1892, СӨБ-910</p>	<p>Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны эрүүл мэндийн үзлэгт 944 багш хамрагдахаас 778 багш хамрагдаж үүнээс хеликобактераар өвчилсөн 259 багш байна. ХҮҮ-ний ажилчид 308 хамрагдахаас 305 хүн хамрагдсанаас нянгаар үүсгэгдсэн арьс салстын өвчлөл 2 илэрсэнийг эмчилгээ хийлгэсэн байна. СӨББ-ын багш, ажилтны эрүүл мэндийн үзлэгт 534 багш хамрагдахаас 527 багш хамрагдаж үүнээс зонхилон тохиолдож байгаа өвчлөл буюу хеликобактерын шинжилгээг 458 багш өгсөнөөс 126 нь өвчилсөн гэж гарсан бөгөөд эрүүлжүүлэх ажлыг зохион</p>	100%

						байгуулсан . ХҮҮ-ний нийт 305 ажилтнууд шинжилгээ өгч эрүүл гарсан байна. Хүрсэн түвшин: 100%	
3.1.7	ЕБС-ийн суралцагчийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношлогоонд суралцагчийн тодорхой насны давтамжтай хамруулах үйл ажиллагааг тогтмолжуулах	Улсын төөсв	Хамруулсан хүүхдийн тоо	Ахлах, дунд ангийн 9862,	Эхний хагас жилд: Ахлах, дунд анги-8593, бага анги-7159 Жилийн эцэст: Ахлах, дунд анги-11593, бага анги-10159	Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт 1-12 дугаар ангийн 18066 хүүхэд буюу 85% хамрагдсан байна. 2-5 настай хүүхдийн өсөлт хөгжлийн судалгаанд нийт хүүхдийн 83% хамрагдсан.бол бие бялдар чийрэгжилтийн сорилд 76% хамрагдсан. Амны хөндийн эрүүл мэндийн үзлэгт ЕБС-ийн 15190 хүүхэд хамрагдсанаас эрүүл шүдтэй хүүхдийн тоо 481, цоорсон шүдтэй 8200, зуултын гажигтай 641, эрүүлжсэн шүдтэй 5523 хүүхэд байна. СӨББ-ын 4790 хүүхэд хамрагдсанаас эрүүл шүдтэй хүүхдийн тоо 1937, цоорсон шүдтэй 2406, зуултын гажигтай 42, эрүүлжсэн шүдтэй 1053 хүүхэд байна. Хүрсэн түвшин: 100%	100%
3.1.9	Төрийн болон төрийн бус иргэдийн оролцоотой орон тооны бус Хүүхдийн хоолны байгуулагдсан зөвлөлөөр хуулийн хэрэгжилт үр дүнг	улсын болон орон нутгийн төсөв	Зөвлөл байгуулагдсан эсэх, үйл ажиллагааны тоо	Зөвлөл-1 арга хэмжээ-0	Эхний хагас жилд: Зөвлөл-1 арга хэмжээ-0 Жилийн эцэст: Зөвлөл-1 арга хэмжээ-1	Аймгийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/186 тоот захирамжийн дагуу "Хүүхдийн хоолны зөвлөл" нь төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой нийт 12 хүний	100%

	хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гарган олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх					бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан. Тус зөвлөл нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилт, сургууль, дотуур байр, цэцэрлэгт хүнсний бүтээгдэхүүн ханган нийлүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, орчин нөхцөлийг сайжруулах, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллаж байна. Ажлын тайланг улирал тутам Засаг даргад тайлагнахаар төлөвлөгөөнд тусгагдсан. Хүрсэн түвшин: 100%	
3.1.1 0	Орон нутгийн иргэдэд насан туршдаа суралцах тэгш боломжийг олгох, иргэнд боловсрол нөхөн олгох ажлыг нэгдсэн удирдлагаар зохион байгуулах	Улсын төсөв	Үйл ажиллагаанд оролцсон иргэдийн тоо	450	Эхний хагас жилд: 500 Жилийн эцэст: 500	Ялгаатай хэрэгцээтэй сургуулийн өмнөх боловсролд 30, ЕБС-ийн 140 сурагч, Улаанбаатар хотын тусгай сургуульд 15, НТБТ-д 47 хүүхэд суралцаж байна. Нийт цэцэрлэг, сургуулийн насны хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн 71,4 хувь нь боловсролд хамрагдаж байна. Жаргалант сумын 3 дугаар сургуулийн харааны бэрхшээлтэй хүүхдийн 1-3 дугаар ангийн 22 сурах бичгийг Улаанбаатар хотын 116	90%

						<p>дугаар сургуульд хүлээлгэн өгч 4-5 дугаар ангийн 27 брайл сурах бичгийг хүлээн сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал хийж 6 настай 24 сургуулийн нэгдүгээр ангид элсэн суралцах хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн эцэг эх, хүлээн авч сургах сургуулийн сургалтын менежер, дэмжлэгийн багийн ахлагч нарын уулзалт хэлэлцүүлэг хийж сургууль, цэцэрлэгт хамрууллаа.</p> <p>Хүрсэн түвшин: 90%</p>	
3.1.1 1	Хичээлийн жилийн бүтцийг мөрдөх, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед хичээл, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах, арга хэмжээ хэрэгжүүлэх	Улсын болон орон нутгийн төсөв	БС-ын А/350, А/398 дагуу сургалтын үйл ажиллагаа явагдсан эсэх	0	Эхний хагас жилд: 0 Жилийн эцэст: 0	2025 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Баруун бүсийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан Гамшгаас хамгаалах мэргэжлийн бүлгийн сургалт-д СӨББ багш ажилчдыг хамрууллаа. Уг сургалтын хүрээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын (СӨББ) сургалт болон эрсдэлийн үнэлгээний үйл ажиллагааг Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч Цогзаяатай хамтран зохион байгуулсан болно. Сургалтад СӨББ-ын 8	90%

					<p>байгууллагын 132 багш, ажилтан хамрагдсан. Багш, ажилчид гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлж, байгууллагынхаа эрсдэлийг үнэлэх арга зүйд суралцсан. Гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, сайжруулах мэдлэг, чадамж эзэмшсэн. Байгууллагууд ажлын байран дахь эрсдэлийг тодорхойлох, бууруулах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах төлөвлөлт хийхэд анхаарч, хамт олны багийн зохион байгуулалт, уялдаа холбоо, хамтын ажиллагаа сайжирсан. Хүүхдэд чиглэсэн аюулгүй ажиллагааны дадлага сургуулилт зохион байгуулах нөхцөл, орчин бүрдсэн. Иймд уг сургалт нь оролцсон байгууллагуудад бодит хэрэгцээнд тулгуурласан, практик мэдлэг олгосон, үр дүнтэй сургалт болсон гэж дүгнэж байна. Онцгой байдлын ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар хамтран баталсан 2025-2026 оны хичээлийн жилд “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Ерөнхий боловсролын сурагчдад гамшиг, эрсдэлийн тухай мэдлэг чадвар</p>
--	--	--	--	--	--

						<p>эзэмшүүлэх, өөрийгөө болон бусдыг тохиолдож болзошгүй гамшиг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнд бэлэн байх, бусдад туслах ухамсар төлөвшүүлэх зорилгоор “Аюулгүй амьдрах ухаан” сургалтыг бие даалтын долоо хоногт хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Хүрсэн түвшин: 90%</p>	
3.1.1 2	Орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын статистик мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж, заасан хугацаанд тайлагнах, сурталчлах	Улсын төсөв	Орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын статистик мэдээнд хамрагдсан байгууллагын тоо	65	Эхний хагас жилд: 66 Жилийн эцэст: 66	2025-2026 оны хичээлийн жилийн намрын статистик тайлан мэдээг Ерөнхий боловсролын 25 сургууль, насан туршийн суралцахуйн 2 төвөөс Байгууллага, ажилтан, бүлэг суралцагчийн тайланг 38 маягтаар, Сургалтын орчны тайланг 4 маягтаар, Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тайланг 4 маягтаар, Сурах бичиг, сурдаггүй хүүхдийн тайланг 6 маягтаар, Хөгжлийн бэрхшээлтэй ажилчдын тайланг 2 маягтаар нийт 54 маягтаар хүлээн авсан. Мөн төрийн өмчийн 34 цэцэрлэг, хувийн өмчийн 4 цэцэрлэг нийт 38 байгууллагаас СӨБ 10-р сар тайланг 13 маягтаар, Сургалтын орчин, ус ариун цэврийн тайланг 4 маягтаар, Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчийн	100%

						тайланг 2 маягтаар нийт 19 маягтын дагуу захиргааны болон албан ёсны статистик мэдээллийг гаргуулж өмнөх жилийн мэдээтэй харьцуулж тайлбар авч, бодит байдалтай зөрүүтэй гэж үзсэн тоон мэдээлэлд тайлбар, залруулга хийлгэж мэдээний хугацаанд тайлагнаж дээд шатны байгууллагад мэдээллийг гарган хүргүүлээ. Хүрсэн түвшин: 100%	
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
4.1.	Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ	Улсын төсөв	Боловсролын чанар, хүртээмж нэмэгдсэн байгууллагын тоо	65	66	Сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр СӨББ 88,8-аас 90, ерөнхий боловсролын сургуулийн гүйцэтгэлийн үнэлгээ 81,2-с 81,59 болж өссөн байна.	100%
4.1.1	Ялгаатай хэрэгцээтэй (малчин өрхийн, хилчдийн, хөгжлийн бэрхшээлтэй, хүнд нөхцөлд амьдарч буй, шашны сургуульд суралцаж буй) хүүхдийг боловсролд тэгш хамруулах, хөгжлийг дэмжих ажлыг орон нутгийн хэмжээнд удирдан зохион	Улсын төсөв	Хамрагдалтын хувь	85	Эхний хагас жилд: 90 Жилийн эцэст: 90	Ялгаатай хэрэгцээтэй сургуулийн өмнөх боловсролд 30, ЕБС-ийн 140 сурагч, Улаанбаатар хотын тусгай сургуульд 15, НТБТ-д 47 хүүхэд суралцаж байна. Нийт цэцэрлэг, сургуулийн насны хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн 71,4 хувь нь боловсролд хамрагдаж байна. Жаргалант сумын 3 дугаар сургуулийн харааны бэрхшээлтэй хүүхдийн 1-3 дугаар ангийн	100%

	байгуулах;					22 сурах бичгийг Улаанбаатар хотын 116 дугаар сургуульд хүлээлгэн өгч 4-5 дугаар ангийн 27 брайл сурах бичгийг хүлээн сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал хийж 6 настай 24 сургуулийн нэгдүгээр ангид элсэн суралцах хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийн эцэг эх, хүлээн авч сургах сургуулийн сургалтын менежер, дэмжлэгийн багийн ахлагч нарын уулзалт хэлэлцүүлэг хийж сургууль, цэцэрлэгт хамрууллаа. Хүрсэн түвшин: 100%	
4.1.2	9-р ангийн суралцагчдын Математикийн хичээлийн суурь чадварыг нэмэгдүүлэх	Улсын төсөв	Хувь	40	Эхний хагас жилд: 45 Жилийн эцэст: 45	9 дүгээр ангид суралцаж буй сурагчдын математикийн хичээлийн гүйцэтгэлийн дундаж хувийг дээшлүүлэх зорилгоор 2025 оны 03 дугаар сарын 1-ний өдрөөс sugaad.mn цахим платформыг ерөнхий боловсролын 24 сургуулийн 1558 хүүхдэд эрх нээж ажилласан. Тус цахим платформыг үр дүнтэй ашиглах чиглэлээр 3 удаагийн уулзалт, сургалт мэдээллийг нийт багш нар хүргэж ажилласан. 2025 оны анги дэвших шалгалтыг	100%

						<p>Боловсролын үнэлгээний төвөөс боловсруулсан блюпринт, даалгавар боловсруулах аргачлалын хүрээнд А болон Б хувилбар бүхий даалгавар боловсруулж шалгалт авч дүнг нэгтгэхэд 24 сургуулийн 1546 сурагч шалгалтад хамрагдаж дундаж гүйцэтгэл 68,5 хувьтай шалгагдсан байна. Үнэлгээний түвшингээр авч үзвэл I түвшинд 60, II түвшинд 53, III түвшинд 92, IV түвшинд 117, V түвшинд 445, VI түвшинд 259, VII түвшинд 293, VIII түвшинд 227 хүүхэд шалгагдсан амжилтыг үзүүллээ. Гүйцэтгэлийн үнэлгээний математикийн хичээлийн 9-р ангийн бичгийн шалгалтад 8 сургуулийн 8 багш сонгогдон шалгагдаж дундаж 49.1 -д хүрсэн.</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p>	
4.1.3	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж, сургалтын байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувийг нэмэгдүүлэх	Улсын төсөв	Үнэлгээний хувь	83	Эхний хагас жилд: 85 Жилийн эцэст: 85	Сургуулийн удирдлагуудын манлайллыг дэмжих, “Ховдын Ирээдүй” төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангах, байгууллагын менежмент, төлөвлөлт, багшлах үйл ажиллагааны чанар, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг сайжруулахад чиглэсэн	100%

					<p>мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд зорилгоор зохион байгуулсан сургалтад 60 захирал, менежер оролцов. Тус сургалтад “Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, анхаарах асуудлууд” сэдвээр мэдээлэл зөвлөмж өгөв. 2025 оны байгууллага болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах ажлын хүрээнд Боловсролын газраас 25 сургуулийн 54 удирдлагад онлайн уулзалт хийсэн. Мөн 2025 оны гүйцэтгэлийн үнэлгээний дүнг нэгтгэж сургуулийн удирдлага болон хими, эрүүл мэнд, биологи биеийн тамирын багш нар нийт 215 хүнд танилцуулсан. Мөн БЕГ-аас зохион байгуулсан онлайн уулзалтад оролцож гүйцэтгэлийн үнэлгээний мэдээлэл дээр хэрхэн ажиллаж ямар үйл ажиллагааг төлөвлөж буй талаар танилцуулга хийсэн болно. 2024-2025 оны гүйцэтгэлийн үнэлгээнд нийт 1031 багш үнэлэгдэж 26569 сурагч хамрагдсан байна. Багшийн гүйцэтгэлийн дундаж оноо 78.32 өмнөх оноос 0.94 оноогоор ахисан Нийт багш нарын индексийг харвал I-30, II-96, III-146, IV-235, V-524 буюу 49% нь нэмэгдэл үр дүнгийн</p>	
--	--	--	--	--	--	--

						урамшуулал авна. Ерөнхий боловсролын 25 сургууль 81.59% дундаж гүйцэтгэлтэй дүгнэгдсэн. Өмнөх оноос 0.39 өсөлттэй байна Хүрсэн түвшин: 100%	
4.1.4	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар боловсролын салбарын асуудлыг хэлэцүүлэх	Улсын төсөв	Хэлэлцүүлсэн тоо	0	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 2	Аймгийн боловсролын салбарын тулгамдсан асуудлыг танилцуулж боловсролын салбарт хэрэгжүүлэх "Ховдын ирээдүй" төсөл арга хэмжээг Аймгийн ИТ-ийн 2 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Батлуулан явцад Аймгийн засаг даргын зөвлөлд 1 удаа, ИТХ-ын хүний хөгжил, цахим бодлогын хороонд 7 удаа дараа тулгамдаж буй асуудлыг танилцуулсан. Боловсролын салбарт хэрэгжүүлсэн "Ховдын ирээдүй" төсөл арга хэмжээний үйл ажиллагааны тайланг Аймгийн төрийн байгууллагуудын тайлан хэлэлцэх хуралд 1 удаа, Аймгийн иргэдийн хурлын Хүний хөгжил, цахим бодлогын хороонд 1 удаа тайлагнаж, бичмэл тайланг ЗДТГ-ын дотоод хяналт, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Хүрсэн түвшин: 10	100%

4.1.5	Нялх балчир хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх	Улсын төсөв	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хувь	0	Эхний хагас жилд: 0 Жилийн эцэст: 1	Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуулиудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд, нялх балчир хүүхдийн цогц хөгжлийг дэмжих зорилгоор дараах үйл ажиллагааг төлөвлөн, амжилттай хэрэгжүүллээ. 1. Хүүхэд хамгааллын чиглэлээр туршлага солилцох цахим сургалтыг /Нийслэлийн Ерөнхий боловсролын 51-р сургуультай хамтран / уг сургалтад Ховд аймгийн ЕБС-ийн нийгмийн ажилтнууд, сэтгэл зүйчид, дотуур байрны багш нар нийт 86 хүн оролцлоо. 2. Сэтгэл зүйчид, дотуур байрны багш нарт зориулсан сэтгэл зүйн дэмжлэг, арга зүйн цахим сургалтыг /Баянзүрх дүүргийн 48-р сургуулийн сэтгэл зүйч Б. Ганцэцэг 132-р сургуулийн сэтгэл зүйч Э. Энххүслэн 85-р сургуулийн сэтгэл зүйч Л. Азаяа нартай хамтран / уг сургалтад Сэтгэл зүйч, Дотуур байрны багш, Сургуулийн нийгмийн ажилтан, нийт 45 хүн оролцсон. 3. Хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулахтай холбоотой журмын	100%
-------	---	-------------	--	---	--	--	------

					<p>танилцуулга / “Хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулах журам”/ А/279 тушаал 2025 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж ирсэнтэй холбоотойгоор 2025 оны 1-р сарын 1-нээс 6-р сарын 30-ны хооронд тус зардлын зарцуулалтын тооцооллыг авч, зарцуулалт зөв эсэхэд хяналт тавьж, үнэлгээ хийсэн. Хяналтаар илэрсэн зөрчлүүдийг нэгтгэн зөвлөмж болгон боловсруулж, СӨББ-ын эрхлэгч нарт 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн уулзалтаар хүргэж, хэлэлцүүлэг өрнүүлсэн. 4. Хүүхэд хамгааллын бодлого, хэрэгжилтийн зөвлөн туслах үйлчилгээ Хүүхэд хамгааллын багийн ахлагч нарт "Хүүхдийг соёл, урлаг, спортын үйл ажиллагаанд оролцуулахад баримтлах журам"-ыг танилцуулах сургалтыг 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Аливаа үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, тээвэрлэх үед жолооч болон харгалзан авч яваа хүнтэй хариуцлагын гэрээ заавал хийхийг анхааруулсан. 5. Нялх балчир хүүхдийн цогц хөгжлийг дэмжих ажлын хүрээнд Хөлийн тавхайн</p>	
--	--	--	--	--	--	--

						<p>үзлэгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвтэй хамтран 9 цэцэрлэгт оношилгоог хийсэн. 6. СӨББ-ын хүүхдүүдийн дунд эрсдэлийн бүлгийн судалгааг авч, Гараас гарт хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p>	
4.1.6	Цахим сургуульд сонгон судлах хичээлээр судалж буй ахлах ангийн суралцагчдын ирц, хамрагдалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Улсын төсөв	Ахлах ангийн цахим сургуулийн сонголт ирцийн хүвь, цахим сургуульд багшлах багшийн тоо	85%, 13 багш	Эхний хагас жилд: 93%, 15 багш Жилийн эцэст: 98%, 18 багш	2025-2026 оны хичээлийн жилд 24 сургуулийн 10 дугаар ангийн 155 сурагч, 11 дүгээр ангийн 138 сурагч, 12 дугаар ангийн 130 сурагч нийт 423 сурагч Medle цахим сургуульд цахимаар суралцаж байна. Цахимаар сонгон суралцаж буй сурагчдад сургуулийн удирдлагууд болон анги удирдсан багш нараар дамжуулж ирцийн мэдээллийг сурагчдад цаг тухай бүрт нь хүргэж сурагчдын идэвхийг нэмэгдүүлж сургуулиуд сурагчдыг цахим хичээлд оролцох боломжоор бүрэн ханган ажиллаж байна. Цахим хичээлдээ хамрагдахгүй байгаа сурагчдыг шалтгааныг тодруулан хичээлд хамрагдах оролцоог нэмэгдүүлж байна. Medle цахим сургуульд нийт 20 багш багшилж хичээл зааж	100%

						байна. Хүрсэн түвшин: Ахлах ангийн цахим сургуулийн сонголтийн ирцийн хувь-75%, цахим сургуулийн багш-20		
4.1.7	ЕБС-ийн дунд, ахлах ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагааг зохион байгуулах	Улсын болон ОНТ	Сургалтын Хамрагдсан хүүхдийн тоо	тоо,	Сургалт-10, Сурагч-3620	Эхний хагас жилд: Сургалт-10, Сурагч-3620 Жилийн эцэст: Сургалт-15, Сурагч-4049	ЕБС-ийн ахлах, дунд ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор нийт 41 удаагийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 7893 суралцагчдыг хамруулан ажилласан байна. Үүнд: Ховд аймгийн ХХҮГ, Эм эс девелопмент консалтинг ХХК-тай хамтран Ховд аймгийн 17 сумын 25 ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хамруулж ажилласан. Хөдөө аж ахуйн их сургууль, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Говь-Алтай аймаг дахь салбар сургуультай хамтран ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонголтоо хэрхэн хийх талаарх сургалтыг ерөнхий боловсролын ахлах дунд ангийн бүх сурагчдыг хамруулан зохион байгуулсан. Татвар төлөгчдийн өдрүүдийн хүрээнд Ховд аймгийн татварын газартай хамтран Прогресс сургуулийн 11	100%

					<p>болон 12 дугаар ангийн сурагчдыг тухайн байгууллагын үйл ажиллагаатай танилцуулж санхүүгийн чиглэлийн мэргэжлийн талаарх мэдээллийг өгч ажилласан. МУИС-ийн Баруун бүсийн сургуулийн санхүүгийн чиглэлийн 4 дүгээр дамжааны оюутнуудыг Ховд аймгийн татварын газрын үйл ажиллагаатай танилцуулах арга хэмжээг зохион байгууллаа.Ховд аймгийн хөгжил политехник коллеж, ХХҮГ, “grand labor job” ХХК-тай хамтран ажил мэргэжлийн зөвлөгөө үйлчилгэний хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн цахим систем ejob платформ, хөдөлмөрт бэлтгэх нь сэдвээр техникийн боловсрол болон мэргэжлийн боловсролын 1 жилийн ангийн 125 суралцагчдад зөвлөх үйлчилгээний сургалтыг зохион байгуулсан.2025-2026 оны хичээлийн жилд шинээр элссэн 1-р дамжааны суралцагчдыг мэргэжлээрээ бахархах, мэргэжлийн итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны онцлаг бүтэц, зохион байгуулалттай танилцуулах зорилгоор</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>мэргэжил тус бүрийн төлөөлөл 1-р дамжааны 45 суралцагч 5 багш "Ховд эко цемент -ийн үйлдвэртэй танилцуулсан. Туршлагаа түгээн дэлгэрүүлэе уулзалт сургалтыг зохион байгууллаа. Тус уулзалт сургалтад салбар бүрийн төлөөлөл оролцлоо. АМЧБО-н нэгдсэн төлөвлөгөөг батлуулан 25 ЕБС-д хүргүүлэн, ажлын хэсгийн гишүүдийг чадавхижуулах сургалтыг 2 удаа зохион байгуулж ажилласан.</p> <p>Хүрсэн түвшин: ЕБС-ийн ахлах, дунд ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор нийт 41 удаагийн сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 7893 суралцагчдыг хамруулан ажилласан байна.</p>	
4.1.8	<p>Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хамтын оролцоог дэмжсэн клуб, дугуйлангийн үйл ажиллагааг дэмжих ажлыг зохион байгуулах;</p>	<p>Улсын болон орон нутгийн төсөв</p>	<p>Клуб, дугуйлангийн төрлийн тоо, Хамрагдсан хүүхдийн тоо</p>	<p>13 төрөл, 14202 сурагч</p>	<p>Эхний хагас жилд: 13 төрөл, 14202 сурагч Жилийн эцэст: 15 төрөл, 18000 сурагч</p>	<p>1. Хичээлээс гадуурх үйл ажиллагааны хамрагдалт ЕБС-ийн сурагчийн хамрагдалт: 15–20 төрлийн дугуйланд 17,215 сурагч тогтмол хамрагдаж байна. СӨБ-ын хүүхдийн хамрагдалт: 2,683 хүүхэд хамрагдаж байна. Төлбөртэй дугуйлангийн хамрагдалт: Аймгийн хэмжээнд урлаг,</p>	100%

					<p>спорт зэрэг чиглэлээр 1,439 хүүхэд хамрагдаж байна. /спорт, гар урлал, технологи, байгаль орчин, танин мэдэхүй, нийгмийн оролцоо/ зэрэг чиглэл давамгайлж байна. Сургуулиудын санаачилга нэмэгдэж, сурагчдын оролцоо аажмаар өсөж байна. 2. 2025 оны 04 дүгээр сарын 15нд "Шинэ боломж амжилтын нууц" сэдэвт ангийн сурагчдын хичээл сонголтод зориулсан уулзалтыг зохион байгууллаа. Уг уулзалтад 11-12 ангийн аймгийн төвийн 135 сурагч хамрагдсан. 3. Өсвөрийн сэргийлэгч бүлгэмийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 2025 оны 04 сарын 30 өдөр "Аймгийн өсвөрийн сэргийлэгч бүлгэм-2025" аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан. Энэхүү тэмцээний аварга баг /Жаргалант-3 сургууль/ бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож 2-р байранд шалгарсан амжилт үзүүллээ. Мөн сурагчид олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт өөрсдийн үйл ажиллагааг бусад хүүхдэд сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулав. 4. 2025</p>	
--	--	--	--	--	--	--

						<p>оны 09 сарын 01 өдрийг угтан Уул уурхай ба эмэгтэйчүүдийн оролцоо сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Энэхүү сургалтын ач холбогдол сүүлийн жилүүдэд охид уул уурхайн салбарыг сонгох нь нэн ховордож байгаа учир танин мэдүүлэх түгээн дэлгэрүүлэх зорилгоор 9-12 ангийн сурагчдад энэхүү үйл ажиллагааг хийж явуулсан.</p> <p>Хүрсэн түвшин: 15-20 дугуйланд 17215</p>	
4.1.9	Цэцэрлэг, сургууль, дотуур байрны орчны стандартыг хангуулах ба орчны ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэх	Улсын төсөв	Ариутгал цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хэвшсэн байгууллагын тоо	66	Эхний хагас жилд: 66 Жилийн эцэст: 67	<p>Эрүүл цэвэр орчин бүрдүүлэхээр сар бүр сургалтын байгууллагын ажилчид байгууллагынхаа орчны 50-1500м2 талбайг цэвэрлэж, 7 хоног бүр эмчийн хяналтад байгууллагын өрөө тасалгааны цэвэрлэгээ ариутгал, халдваргүйжүүлэх ажлыг хийж байна. 2025 оны 1 дүгээр сард сурагчдын амралтаар ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар сургууль, цэцэрлэгийн нийт 89584,24 м2 талбайг, байгууллагын гадна 9153 м2 талбайг цэвэрлэж халдваргүйжүүлсэн.</p> <p>Улаанбурхан өвчний тархалт эхэлсэнээс хойш ариутгал</p>	100%

						халдваргүйтгэлийн дэглэм, тусгаарлах өрөө бэлтгэн ажиллаж байна. Хүрсэн түвшин: 100%	
4.1.1 0	Боловсролын байгууллагын орчинд хүүхдийг аливаа хэлбэрийн дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлж ажиллах	Улсын болон орон нутгийн төсөв	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	2	Эхний хагас жилд: 3 Жилийн эцэст: 4	Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах, үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн сэтгэл зүйд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор Ховд аймагт үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг олон талт нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгууллаа. Эдгээр арга хэмжээ нь төрийн болон төрийн бус байгууллага, хүүхэд, залуучуудын байгууллага, иргэдийн оролцоо, хамтын ажиллагаанд суурилсан байдлаараа онцлог бөгөөд дараах гол үйл ажиллагаануудыг зохион байгуулсан. Үүнд: "Тэгш оролцоо – Хязгааргүй боломж" сэдвийн хүрээнд Flash mob арга хэмжээ зохион байгуулж, хүүхэд, залуучуудын тэгш оролцоог уриалсан, хүчирхийллийн эсрэг нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн олон нийтийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэв. "Youth Power - Khovd" байгальд ээлтэй залуучуудын чуулганд үе	100%

					<p>тэнгийн дээрэлхэлт, цахим хүчирхийллийн сэдвийг хөндөн хэлэлцүүлэг өрнүүлж, залуучуудын оролцоотойгоор урьдчилан сэргийлэх шийдлүүдийг тодорхойлов. "Teenshot in Khovd" залуучуудын нөлөөллийн хөдөлгөөнд үе тэнгийн дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтаас ангид байх уриатай бүтээлч залуус нэгдэж, олон нийтэд эерэг хандлагыг түгээв. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран “Цахим орчин ба хүүхэд хамгаалал” зохион байгуулж, сурагчдын дунд цахим хүчирхийлэл, сөрөг хандлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, эерэг хэрэглээг дэмжих бүтээлч арга хэмжээг өрнүүлсэн. 2025 оны 04 сарын 30 өдөр Хүүхдийг зодож шийтгэхээс ангид өдрийг Жаргалант сумын ерөнхий боловсролын сургууль, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран зохион байгууллаа. 2025 оны 9 дүгээр сарын 22-с Гэр бүлийн үнэ цэнэ хүүхэд бидний ирээдүй нэрийн дор 14 хоногийн аяныг зохион байгуулсан. Энэхүү аяны хүрээнд шөнийн болон өдрийн эргүүл, төвийн сургуулиудад хууль таниулан</p>	
--	--	--	--	--	---	--

						сурталчлах үйл ажиллагааг зохион байгууллаа. Хүрсэн түвшин: 100%	
4.1.1 1	Сургалтын чанарыг сайжруулах чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагатай хамтран ажиллах	Улсын төсөв	Төсөл арга хэмжээний тоо	0	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 1	“Эрдмийн баяр- Ажлын гараа” өдөрлөгийг 2025 оны 05 джгаар сарын 19-ний өдөр зохион байгуулж 81 дахь удаагийн төгсөлтөөр Техникийн боловсрол олгох 7 мэргэжлээр 70 суралцагч, Мэргэжлийн боловсролын 1 жилийн 21 мэргэжлээр 361 суралцагч амжилттай төгсөж, тэдний 45 хувь нь ажлын байранд зуучлагдлаа. Хөдөлмөр эрхлэлт 2023-2024 оны төгсөгчид 71,2%, 2024-2025 оны төгсөгчдийн 71,15 хувь нь тус тус ажлын байртай болсон байна Хүрсэн түвшин: 100%	100%
4.1.1 2	Ахмад багш нарын холбоотой хамтран сурлагын чанарыг нэмэгдүүлэх ажилд тэднийг татан оролцуулах	Улсын болон ОНТ	үйл ажиллагааны тоо	0	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 1	Ахмад багш нарын холбоотой хамтран Ахмад багшийн дэм технологийн олимпиадыг 6 дугаар сургуулийн мэргэжлийн бүлэгтэй хамтран 2025.12.23 өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Хүрсэн түвшин: 70	90%
4.2.	Менежмент, хүний нөөц, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогыг үр дүнтэй	Улсын батлагдсан төсөв	үйл ажиллагааны тоо, хөрөнгө оруулалтын дүн	0	3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2025 он дамжин 56,7 тэрбум төгрөгний 12 төсөл арга	100%

хэрэгжүүлнэ					<p>хэмжээ хэрэгжиж ажлын гүйцэтгэл 76%-тай үргэлжилж байна. Үүнд: 6 цэцэрлэг, 3 сургууль, 3 дотуур байрны ажил үргэлжилж байна. 2025 онд хүлээн авах он дамжин хэрэгжиж байгаа багш хөгжлийн төв, бичигт багын цэцэрлэг, бага сургууль цэцэрлэгийн цогцолборын барилгын асуудлыг шийдвэрлэхээр Аймгийн засаг даргад уламжлаад байна. Бусад төсөл арга хэмжээний хувьд барилга угсралтын ажил хэвийн үргэлжилж байна. 2025 оны 11 сард Манхан сумын сургууль/240 суудал/, 2025 оны 12 сард бичиг багын цэцэрлэг/150 ор/, Манхан сумын дотуур байр/200 ор/, Жаргалант сумын 4-р цэцэрлэг/150 ор/ зэрэг төсөл арга хэмжээг хүлээн авахаар төлөвлөж байна. Аймгийн ИТХ 2 дугаар тогтоолоор "Ховдын ирээдүй" төсөл арга хэмжээ 2 тэрбум төгрөгөөр батлагдаж хэрэгжиж эхэллээ. Үүний хүрээнд бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд 220 сая төгрөгийн 1-3 ангийн Стем тоглоом, сургууль цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг 70 сая</p>	
-------------	--	--	--	--	--	--

						төгрөгөөр тус бүр тендер зарлаж гүйцэтгэгч компани нийлүүлээд байна. сургалтын байгууллагын санал хүсэлтэд үндэслэн хуваарилалтыг хийж байна.	
4.2.1	Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын хүний нөөцийн чадавх болон материаллаг орчныг бэхжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тэдний үйл ажиллагааг цэцэрлэг, сургууль, багш нарт мэргэжил арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд бүрэн чиглүүлж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;	Орон нутгийн төсөв-300.0	хэрэгжилтийн хувь	96,4 сая	Эхний хагас жилд: 150.0 Жилийн эцэст: 300 сая	Аймгийн ИТХ 2 дугаар тогтоолоор "Ховдын ирээдүй" төсөл арга хэмжээ 2 тэрбум төгрөгөөр батлагдаж хэрэгжиж эхэллээ. Үүний хүрээнд бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд 220 сая төгрөгийн 1-3 ангийн Стем тоглоом, сургууль цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг 70 сая төгрөгөөр тус бүр тендер зарлаж гүйцэтгэгч компани нийлүүлээд байна. сургалтын байгууллагын санал хүсэлтэд үндэслэн хуваарилалтыг хийж байна. Мөн ахлах ангийн сурагчдын математик боловсролыг дээшлүүлэх suraad.mn сургалтын платформын төлбөр 106,4 сая төгрөгийн төлбөр, хүүхдийн нүдний харааг 9 ширхэг оношлох аппаратыг орон нутгийн санхүүжилтийн 16 сая төгрөгөөр худалдан авалт хийж сургуулиудад хуваарилан хүргүүлсэн.	100%

						Хүрсэн түвшин: 100%	
4.2.2	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн хангалтыг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх;	Улсын болон ОНТ	Мэргэжлийн багш хангалтын хувь, Үзүүлсэн дэмжлэгийн тоо	94%, 44 багш	Эхний хагас жилд: 96%, 44 багш Жилийн эцэст: 98%, 20 багш	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн хангалтийг нэмэгдүүлэх чиглэлээр орон нутаг дахь МУИС-ийн Баруун бүсийн сургуулийн төгсөх ангийн оюутнуудыг багш дутагдалтай байгууллагуудад цалинтай ажиллуулах арга хэмжээ авч ажилласан. Тухайн хугацаанд төгсөх ангийн 18 оюутан сумын сургуульд мэргэжлээрээ ажилласан. Хүрсэн түвшин: мэргэжлийн багшийн хангалт 98%, 15 багш тус бүр 30 сая	100%
4.2.3	Аймгийн хэмжээнд багш, удирдах болон бусад ажилтныг ёс зүйгүй аливаа үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж үр дүнг тооцож ажиллах;	Улсын болон ОНТ	Зохион байгуулсан сургалтын тоо, үр дүнгийн хэрэгжилт	0	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 2	Ховд аймгийн ерөнхий боловсролын 25 сургуулийн захирал, менежерүүдэд багш, ажилтны ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, багш, удирдах болон бусад ажилтныг ёс зүйгүй аливаа үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээг 2 дугаар сарын 2-3-ны өдрүүдэд Боловсролын газрын дарга мэргэжилтнүүд хамтран зохион байгууллаа. Сургалтад нийт 25 сургуулийн 80 удирдлага	100%

					<p>оролцлоо. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм”, “Ёс зүйн дэд хорооны үлгэрчилсэн журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар боловсруулсан төслийг нийт цэцэрлэг, сургуулийн эрхлэгч, захирал, багш, ёс зүйн дэд хорооны төлөөллөөр хэлэлцүүлээ. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу 24 сургууль, 33 цэцэрлэгт ёс зүйн дэд хороо байгуулсан мэдээллийг сургууль, цэцэрлэгүүдээс авч нэгтгэж ТАЗ-д хүргүүллээ. ЕБС-ийн ёс зүйн дэд хорооны 139 гишүүн, 33 цэцэрлэгийн ёс зүй дэд хорооны 136 гишүүдийг төрийн албаны зөвлөлийн цахим сургалтад хамрууллаа. Мөн Боловсролын ерөнхий хуулийн сургалтад 24 сургуулийн захирал, сургалтын менежер, 80 багш нарыг хамрууллаа.</p> <p>Хүрсэн түвшин: 100%</p>	
--	--	--	--	--	---	--

4.2.4	Сургалтын байгууллагын эзэмшил газрыг баталгаажуулах, сургууль, цэцэрлэгийн эдэлбэр, эзэмшил газарт зориулалтын бус барилга байгууламж, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохгүй, сургалтын үйл ажиллагаанд ашиглахаас өөр зориулалтаар өргөтгөл нэмж барихгүй байх барилга угсралтын гэрээний хэрэгжилтийг хангаж, цаг хугацаанд нь ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх, хяналт шалгалт хийх;	Улсын төсөв	Хяналтын тоо	1	Эхний хагас жилд: 1 Жилийн эцэст: 2	Сургууль цэцэрлэгийн барилгын өргөтгөл, шинэ барилгатай холбоотой стандартын бус барилга байгууламжид байрлаж буй Жаргалант сумын 2, 6 дугаар цэцэрлэгийн байрлаж буй байрыг стандарт түвшинд ойртуулах шаардлагыг удаа дараа тавьж ажилласан. Хүрсэн түвшин: 90%	90%
4.2.5	Байгууллагын болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах	Улсын төсөв	Төлөвлөгөө боловсруулсан албан хаагчийн тоо	15	Эхний хагас жилд: 16 Жилийн эцэст: 18	Боловсролын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн 7 ахлах арга зүйч, сургалт арга зүйн хэлтсийн 7, захиргаа удирлагын хэлтсийн төрийн захиргааны 2 ахлах арга зүйч нийт 16 төрийн захиргааны албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг тайлагнасан.	100%

						Хүрсэн түвшин: 100%	
4.3.	Боловсролын салбарын санхүү, төсвийн удирдлага, хэрэгжилтийг ханган ажиллана	Улсын төсөв	Төсвийн зарцуулалт зөв хийсэн байгууллагын тоо	65	66	ЗГ 2024 оны цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоол №238, хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэх тухай тогтоол №254, Боловсролын сайдын зардлын заавар батлах тухай 2024 оны А/279 тушаал, Багш ажилтны цалин нийгмийн баталгааг хангахтай холбоотой, туслах багш ажиллуулах чиглэлүүдийг нэгж байгууллагуудад хүргүүлэн танилцуулга мэдээллээр хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж байна. Боловсролын сайдын 2024 оны А/279 зардлын заавар батлах тухай тушаалаар баталсан ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын “Хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөх, зарцуулах тайлагнах” заавар аргачлал, 2025 оны төсвийг хэрэгжүүлэх чиглэлийг нийт захирал, эрхлэгч нарт танхимаар мэдээлэл өгч ажиллав. Мөн санхүүгийн ажилтануудад дээрх сэдвээр цахим байдлаар танилцуулга бэлдэж мэдээлэл өгөв. Мөн	100%

						төсвийн тодотголтой холбоотой чиглэл, Сайдын унаа хоолны хөнгөлөлт, ажил хаялтын үеийн нөхөн олговор зэрэг цаг үеийн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн арга зүйгаар ханган ажиллав.	
4.3.1	Төсвийн тухай хуулийн 14.2.2 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 38.1 дэх хэсэгт заасан зохицуулалтыг бүрэн хангаж ажиллана;	Улсын болон орон нутгийн төсөв	Эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох, санхүүжүүлэх	ЕБС-70.7 тэрбум, СӨБ-32.3 тэрбум,	Эхний хагас жилд: ЕБС-75.8 тэрбум, СӨБ-34.1 тэрбум, Жилийн эцэст: ЕБС-75.8 тэрбум, СӨБ-34.1 тэрбум,	Орон нутгаас байр ашиглалтын тогтмол зардлыг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 оноос эхлэн боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан төсвийн шинэчлэлийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хүрсэн түвшин: ЕБС-74,07 тэрбум, СӨБ-30,2 тэрбум	100%
4.3.2	Хөрөнгө оруулалтын саналыг Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж, эрх бүхий байгууллагаар баталгаажсан зураг, төсвийн хамт ирүүлэх;	Улсын болон орон нутгийн төсөв	Хүргүүлсэн саналын тоо	шинэ сургууль-4, шинэ цэцэрлэг-3, шинэ дотуур байр-2	Эхний хагас жилд: шинэ сургууль-4, шинэ цэцэрлэг-3, шинэ дотуур байр-2 Жилийн эцэст: шинэ сургууль-3, шинэ цэцэрлэг-3, шинэ дотуур байр-1	Боловсролын салбарын шинэ хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө барилгын зураг болон газрын асуудлыг бүрэн шийдвэрлэсэн, мэргэжлийн байгууллагын санал дүгнэлт гарсан төсөл арга хэмжээний мэдээллийг Сангийн яамны хөрөнгө оруулалтын удирдлагын системд /pimis.gov.mn/ 2025 оны 06 дугаар сарын 25-ний дотор 2026-2028 онд шинээр эхлэх 7 төсөл арга хэмжээний мэдээллийг оруулж байна. Төсвийн тухай хуулийн дагуу 2026 оны дунд	100%

						хугацааны төсвийн төслийг хуулийн хугацаанд төлөвлөн хүргүүлээ. Хүрсэн түвшин: 100%	
4.3.3	Сургалтын байгууллагын хэвийн үйл ажиллагааг доголдуулахгүй байх, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, тогтмол зардлын өр үүсгэхгүй байх, барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний зардлын гүйцэтгэлд хяналт тавих	Орон нутгийн төсөв	Хуваарилагдсан төсөв Гүйцэтгэлийн хувь	10,011 сая төгрөг	Эхний хагас жилд: 10,300 сая төгрөг Жилийн эцэст: 10,300 сая төгрөг	Боловсролын байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах тогтмол зардлыг Аймгийн ИТХ тогтоолоор төсөвлөн хэрэгжүүлж байна. Аймгийн хэмжээнд 59 сургалтын байгууллагын тогтмол зардал, урсгал засварын зардалд 2025 онд 14 448,9 сая.төгрөг батлагдаж төсвийн жилийн дундуур төсөвт тодотгол орж 12 377,4 сая төгрөг болж буурсан. Санхүү эрчим хүчний зохицуулах салбар зөвлөлөөс тогтоосон тарифаар 2025 оны эхний хагас жилийн үнийн зөрүү Жаргалант сумын 4 сургууль 250,8 сая төгрөг, 7 цэцэрлэг 87,4 сая төгрөг нийт 11 байгууллага 338,2 сая төгрөгийн өглөг үүссэн бөгөөд нэмэлт тодотголоор шийдвэрлэгдсэн. Тухайн батлагдсан төсөвт багтаан 2025 оны төсвийн жилд тогтмол болон урсгал засварын зардлын өглөг үүсэхгүй байх зохицуулалт хийж ажиллав	100%

						Хүрсэн түвшин: 100%	
4.3.4	Боловсролын салбарын төсвийн шинэчлэл, цахим шилжилттэй холбоотой үйл ажиллагааг дэмжин ажиллах, холбогдох тооцоо судалгаа, цахим төсвийн төслийн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах	Орон нутгийн төсөв	Цахим болон танхимын уулзалт зөвлөгөөний тоо,	Цахим төсвийн төсөл, тэтгэвэр, тэтгэмжийн талаар 24 сургууль, 33 цэцэрлэгт 11 удаагийн цахим уулзалтаар нийт ЕБС-426, СӨБ-273 багш, ажилтанд мэдээлэл өгөв. Танхимаар-21 нягтлан бодогч хамрагдсан	Эхний хагас жилд: Цахим төсвийн төсөл, тэтгэвэр, тэтгэмжийн талаар 25 сургууль, 34 цэцэрлэг 12 удаагийн танхим болон цахим уулзалтаар нийт ЕБС-600, СӨБ-350 багш, ажилтанд мэдээлэл өгнө. Жилийн эцэст: Цахим төсвийн төсөл, тэтгэвэр, тэтгэмжийн талаар 25 сургууль, 34 цэцэрлэг 12 удаагийн танхим болон цахим уулзалтаар нийт ЕБС-600, СӨБ-350 багш, ажилтанд	Боловсролын салбарын төсвийн шинэчлэлийн хүрээнд төсвийн төслийн суурь бааз болох Боловсролын мэдээллийн систем түүний хүүхдийн тоо, суралцагчийн бүртгэл, багш ажилтан хүний нөөцийн мэдээллийг шинэчлэх ажлын талаар сургууль, цэцэрлэгүүдэд мэдээлэл хүргэн хэрэгжилтийг ханган ажиллаа. Мөн сургалтын 65 байгууллагын 2026 оны төсвийн төслийн саналыг төсвийн төвлөрүүлэн захирагчид хуулийн хугацаанаас өмнө буюу 06 дугаар сарын 27-ний дотор төсвийн төслийн цахим систем болох Fin.esis.edu.mn- ээр нэгтгэн хянаж хуулийн хугацаанд цахим системээр илгээв. Дээрх цахим системийн холбогдох дүнгүүдийг цаасаар баталгаажуулан хүргүүлээ Хүрсэн түвшин: 100%	100%

					мэдээлэл өгнө.		
4.3.5	Төсвийн ерөнхийлөн болон шууд захирагчийн шийдвэрээр ажиллах дотоод аудит, хяналт шалгалтын ажлын хэсгийг шаардлагатай мэдээллээр хангах, санхүүгийн тайлан, мэдээнд дүн шинжилгээ хийж ажиллах	Улсын болон орон нутгийн төсөв	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо	өөрчлөлтгүй-54 хязгаарлалттай-4 сөрөг-1 татгалзсан-0	Эхний хагас жилд: өөрчлөлтгүй-57 хязгаарлалттай-2 Жилийн эцэст: өөрчлөлтгүй-57 хязгаарлалттай-2	байна. 2025 онд зөрчил зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг хангах чиглэлээр салбарын байгууллагууддаа мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажилллаа. 2025 оны 5 сард Мөст, Булган, Мөнххайрхан суманд томилолтоор, Жаргалант сумын 7 сургууль, 16 цэцэрлэгт ажлын байранд дээр зөвлөн тусаллаа. Хүрсэн түвшин: 95%	90%
4.4.	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллана	Улсын төсөв	Албан хэрэгцээнд хос бичиг хэрэглэж байгаа байгууллагын тоо	65	66	Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай Аймгийн Засаг даргын 1/144 тоот албан бичгийг бүх сум байгууллагад хүргэсэн. Энэ хүрээнд боловсролын салбарын тоон мэдээллийг нэгтгэж үзэхэд ЕБС, СӨБ, Боловсролын газар нь тушаал, албан бичиг, тодорхойлолт, хурлын тэмдэглэл гэсэн 4 төрлийн 1936 баримт бичгийг хос бичгээр үйлдсэн байна. Төрийн албан хаагчдын монгол бичгийн цахим хэрэглээг нэмэгдүүлэх, монгол бичгээр цахим бичвэр боловсруулах ур чадварыг дээшлүүлэх	100%

					<p>зорилгоор “Үндэсний бичгийг цахимаар бичих арга зүй” сургалтыг 10 байгууллагын 120 багш, ажилтнуудад зохион байгууллаа. Сургалтаар “Монгол бичгийг сурахын ач холбогдол”-ын талаар мэдээлэл өгч, CMS, mongolian baiti фонтоор хэрхэн цахимд бичих дадлага ажил хийлээ. Мөн Монгол бичгийн стандарт тавигдах шаардлага, анхаарах асуудлаар зөвлөгөө өглөө. Тус сургалтад сумын ИТХ-ын нарийн бичиг, ЕБС-ийн бичиг хэрэг, эрх зүйн албан хаагчид хамрагдлаа. Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-ийг “Үндэсний бичиг үсэг-Монгол соёлын үнэт өв” уриатайгаар бичиг үсгийн баярын өдрийг тэмдэглэлээ. Ерөнхий болосролын сургуулиуд өртөө бүрт арга хэмжээ зохион байгуулж шилдгүүдээ тодруулан шагнаж урамшуулав. Үндэсний бичиг үсгийн соёлын өвийн гайхамшгийг сурталчлан таниулах үйл ажиллагааг номын баярын арга хэмжээнээс тусад нь нэг өдөр болгон зохион байгуулсан бөгөөд оролцогчдын тоо нэмэгдсэн, бүтээлч үр дүнтэй</p>	
--	--	--	--	--	---	--

						болсноороо онцлогтой байлаа. Төрийн байгууллагын албан хаагчдын дунд “Сайхан бичгийн уралдаан”-ыг СУАЖЗГ-тай хамтран зохион байгууллаа. Байгууллагын 8 албан хаагчийн хамт “Эрдэнийн сан Субашид” сургаалын зохиолын оршил бүлгийн 30 бадгийг хичээнгүй бичгээр бичиж оролцон тусгай байр эзэллээ.	
4.4.1	“Монгол хэлний тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Улсын төсөв	Хуулийн хэрэгжилт хангасан хувь	50%	Эхний хагас жилд: 75% Жилийн эцэст: 100%	Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай Аймгийн Засаг даргын 1/144 тоот албан бичгийг бүх сум байгууллагад хүргэсэн. Энэ хүрээнд боловсролын салбарын тоон мэдээллийг нэгтгэж үзэхэд ЕБС, СӨБ, Боловсролын газар нь тушаал, албан бичиг, тодорхойлолт, хурлын тэмдэглэл гэсэн 4 төрлийн 1936 баримт бичгийг хос бичгээр үйлдсэн байна. Төрийн албан хаагчдын монгол бичгийн цахим хэрэглээг нэмэгдүүлэх, монгол бичгээр цахим бичвэр боловсруулах ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Үндэсний бичгийг цахимаар бичих арга зүй” сургалтыг 10 байгууллагын 120 багш, ажилтнуудад	100%

					<p>зохион байгууллаа. Сургалтаар “Монгол бичгийг сурахын ач холбогдол”-ын талаар мэдээлэл өгч, CMS, mongolian baiti фонтоор хэрхэн цахимд бичих дадлага ажил хийлээ. Мөн Монгол бичгийн стандарт тавигдах шаардлага, анхаарах асуудлаар зөвлөгөө өглөө. Тус сургалтад сумын ИТХ-ын нарийн бичиг, ЕБС-ийн бичиг хэрэг, эрх зүйн албан хаагчид хамрагдлаа. Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-ийг “Үндэсний бичиг үсэг-Монгол соёлын үнэт өв” уриатайгаар бичиг үсгийн баярын өдрийг тэмдэглэлээ. Ерөнхий болосролын сургуулиуд ертөө бүрт арга хэмжээ зохион байгуулж шилдгүүдээ тодруулан шагнаж урамшуулав. Үндэсний бичиг үсгийн соёлын өвийн гайхамшгийг сурталчлан таниулах үйл ажиллагааг номын баярын арга хэмжээнээс тусад нь нэг өдөр болгон зохион байгуулсан бөгөөд оролцогчдын тоо нэмэгдсэн, бүтээлч үр дүнтэй болсноороо онцлогтой байлаа. Төрийн байгууллагын албан хаагчдын дунд “Сайхан</p>
--	--	--	--	--	---

						бичгийн уралдаан"-ыг СУАЖЗГ-тай хамтран зохион байгууллаа. Байгууллагын 8 албан хаагчийн хамт "Эрдэнийн сан Субашид" сургаалын зохиолын оршил бүлгийн 30 бадгийг хичээнгүй бичгээр бичиж оролцон тусгай байр эзэллээ. Хүрсэн түвшин: 100%	
4.5.	Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлэх.	Улсын төсөв	Хяналт шалгалт хийсэн байгууллагын тоо	65	66	БЯ, БЕГ-аас ирүүлсэн эрсдлийн өөрийн үнэлгээ хийх албан бичгийн дагуу нэгж байгууллага бүрээс өөрийн хичээл сургалтын байр, дотуур байрны өөрийн үнэлгээг хийлгэж судалгааг холбогдох байгууллагад хүргүүлсэн.	100%
4.5.1	Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Боловсролын сургалтын 10 байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийх	Улсын төсөв	Шалгалт хийсэн байгууллагын тоо, албан шаардлагын хэрэгжилтийн хувь	10, 60%	Эхний хагас жилд: 10, 60% Жилийн эцэст: 10, 65%	Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай Аймгийн Засаг даргын 1/144 тоот албан бичгийг бүх сум байгууллагад хүргэсэн. Энэ хүрээнд боловсролын салбарын тоон мэдээллийг нэгтгэж үзэхэд ЕБС, СӨБ, Боловсролын газар нь тушаал, албан бичиг, тодорхойлолт, хурлын тэмдэглэл гэсэн 4 төрлийн 1936 баримт бичгийг хос бичгээр үйлдсэн байна. Төрийн албан хаагчдын монгол бичгийн цахим хэрэглээг нэмэгдүүлэх,	100%

					<p>монгол бичгээр цахим бичвэр боловсруулах ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Үндэсний бичгийг цахимаар бичих арга зүй” сургалтыг 10 байгууллагын 120 багш, ажилтнуудад зохион байгууллаа. Сургалтаар “Монгол бичгийг сурахын ач холбогдол”-ын талаар мэдээлэл өгч, CMS, mongolian baiti фонтоор хэрхэн цахимд бичих дадлага ажил хийлээ. Мөн Монгол бичгийн стандарт тавигдах шаардлага, анхаарах асуудлаар зөвлөгөө өглөө. Тус сургалтад сумын ИТХ-ын нарийн бичиг, ЕБС-ийн бичиг хэрэг, эрх зүйн албан хаагчид хамрагдлаа. Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-ийг “Үндэсний бичиг үсэг-Монгол соёлын үнэт өв” уриатайгаар бичиг үсгийн баярын өдрийг тэмдэглэлээ. Ерөнхий болосролын сургуулиуд өртөө бүрт арга хэмжээ зохион байгуулж шилдгүүдээ тодруулан шагнаж урамшуулав. Үндэсний бичиг үсгийн соёлын өвийн гайхамшгийг сурталчлан таниулах үйл ажиллагааг номын баярын арга хэмжээнээс тусад нь нэг өдөр болгон зохион</p>
--	--	--	--	--	--

						байгуулсан бөгөөд оролцогчдын тоо нэмэгдсэн, бүтээлч үр дүнтэй болсноороо онцлогтой байлаа. Төрийн байгууллагын албан хаагчдын дунд “Сайхан бичгийн уралдаан”-ыг СУАЖЗГ-тай хамтран зохион байгууллаа. Байгууллагын 8 албан хаагчийн хамт “Эрдэнийн сан Субашид” сургаалын зохиолын оршил бүлгийн 30 бадгийг хичээнгүй бичгээр бичиж оролцон тусгай байр эзэллээ. Хүрсэн түвшин: 100%	
4.5.2	Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2025-2026 оны хичээлийн бэлтгэл ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Улсын төсөв	Хяналт шалгалт хийсэн байгууллагын тоо, зөрчил арилгалтын хувь	33, 58,5%	Эхний хагас жилд: 33, 58,5% Жилийн эцэст: 35, 60%	Боловсролын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 03-00/03 дугаар Бүх шатны боловсролын сургалтын байгууллагуудын 2025-2026 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл, ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч Ц.Алтаншиг, Эрүүл мэндийн газрын Хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуйн асуудал хариуцсан эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчтай хамтран Ерөнхий боловсролын	100%

					<p>сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч болон холбогдох ажилчдыг байлцуулан 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс 09 дүгээр сарын 02-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ. Бүх шатны Боловсролын сургалтын байгууллагуудын 2025-2026 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажилд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтанд 21 цэцэрлэг, Ерөнхий боловсролын 10 сургууль нийт 31 байгууллага буюу нийт боловсролын сургалтын байгууллагын 50% нь хамрагдлаа. Удирдамжийн дагуу мэдээллийг хавсралт, хүснэгт 1, 2-ын дагуу гаргалаа. Шалгалтад хамрагдсан байгууллагуудын удирдлагуудад шалгалтын дүнг танилцуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэл өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, шалгалтын дүнг танилцуулсан хяналт шалгалтын танилцуулга 1 үйлдлээ. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн тухай танилцуулгыг хавсралт хүснэгтийн хамт Боловсролын яамны Салбарын хяналтын газарт Munkhzaya@moe.gov.mn цахим хаягаар болон цаасан хэлбэрээр хугацаанд нь тус</p>
--	--	--	--	--	---

						<p>тус хүргүүлээ. Урьдчилан сэргийлэх шалгалтанд Сургуулийн өмнөх боловсролын 37 байгууллагаас 21 буюу 57%, Ерөнхий боловсролын 25 сургуулиас 10 буюу 40%, нийт 62 байгууллагын 50% нь тус тус хамрагдсан байна. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 2025-2026 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил бүрэн хангагдаж хичээл сургалтын үйл ажиллагаа 100% эхэлсэн байна.</p> <p>Хүрсэн түвшин: Хичээлийн шинэ жилийн бэлтгэл бүрэн хангагдсан.</p>	
4.5.3	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн шинэчлэн батлагдсан хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Улсын төсөв	Хяналт хийсэн объектын хувь, Зөрчил арилгалтын хувь	0, 0	Эхний хагас жилд: 100%, 50% Жилийн эцэст: 100%, 50%	<p>Боловсролын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн шинэчлэн батлагдсан хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж ирээгүй болно.</p> <p>Хүрсэн түвшин: Боловсролын яам</p>	100%

4.5.4	Дээд боловсролын сургалтын байгууллагын ахисан түвшний сургалтын хөтөлбөрийн багшийн хүрэлцээ хангамжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Улсын төсөв	Хяналт хийсэн объектын хувь, Зөрчил арилгалтын хувь	0, 0	Эхний хагас жилд: 100%, 50% Жилийн эцэст: 100%, 60%	Боловсролын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 03-00/42 дугаар Ахисан түвшний сургалтын хөтөлбөртэй их, дээд сургуулиудын багшийн хүрэлцээ хангамжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Боловсролын газрын Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч Ц.Алтанхишиг 2025 оны 11 дүгээр сарын 17-20-ны өдрүүдэд хийлээ. Шалгалтад МУИС-ийн Баруун бүсийн сургууль хамрагдлаа. Тус сургуульд Боловсрол шинжлэх ухааны яамны 960001 дугаартай Сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлийг 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдөр олгосон бөгөөд Бакалаврын түвшинд 39 хөтөлбөр, магистрын түвшинд 13 /боловсрол судлал, математикийн боловсрол, түүх, хэл шинжлэл, гадаад хэл шинжлэл, утга зохиол судлал, бизнесийн удирдлага, төрийн захиргаа, биологи, экологи, хими, газар зүй, физик/ хөтөлбөр, докторын түвшинд 6 /боловсрол судлал, түүх, утга	100%
-------	---	-------------	---	------	--	---	------

					<p>зохиол, биологи, хими, газар зүй/ хөтөлбөрөөр тус тус сургалт явуулж байна. Удирдамжийн дагуу мэдээллийг хавсралт, хүснэгт 1, 2, 3-ын дагуу гаргаж шалгалтад хамрагдсан байгууллагын удирдлагад шалгалтын дүнг танилцуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, шалгалтын дүнг танилцуулсан хяналт шалгалтын танилцуулга 1 үйлдлээ. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн тухай танилцуулгыг хавсралт хүснэгтийн нэгтгэлийн хамт Боловсролын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт Naranbaatar@mecs.gov.mn цахим хаягаар болон цаасан хэлбэрээр хугацаанд нь тус тус хүргүүлээ. МУИС-ийн Баруун бүсийн сургууль нийт 77 багш ажилдаг бөгөөд багш нарын 34 буюу 44% нь доктор, 43 буюу 56% нь магистр зэрэгтэй байна. Ахисан түвшний сургалтын хөтөлбөрт 38 багш хичээл заадаг ба үүний 32 буюу 84% нь доктор, 6 буюу 15% нь магистр зэрэгтэй багш ажиллаж байгаа нь ахисан түвшний сургалтын</p>	
--	--	--	--	--	--	--

						хөтөлбөрийн хүрэлцээ шаардлагын түвшинд байна. Хүрсэн түвшин: 100%, 60%		
4.5.5	Элсэлтийн шалгалт байгуулах ажиллагаанд урьдчилан хяналт шалгалт хийх	Ерөнхий зохион үйл ажиллагаанд урьдчилан хяналт шалгалт хийх	Улсын төсөв	Хяналт объектын Зөрчил хийсэн хувь, арилгалтын хувь	100%, 0	Эхний хагас жилд: 100%, 50% Жилийн эцэст: 100%, 75%	Боловсролын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 03-00/21 дугаар 2025 оны Элсэлтийн шалгалт зохион байгуулалтын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч Ц.Алтаншиг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс 21-ны өдрийг дуустал хугацаанд холбогдох хүмүүсийг байлцуулан хийлээ. Ерөнхий боловсролын сургууль төгсөгч элсэлтийн шалгалтанд шалгуулах 1047 шалгуулагч, Боловсролын үнэлгээний төвөөс томилогдон ирсэн зохион байгуулах багийн бүрэлдэхүүн болон холбогдох хүмүүс хамрагдлаа. Боловсролын үнэлгээний төвөөс шалгалтын сэдэв аймгийн Тагнуулын газарт ирсэн байна. Шалгалтын төвд 2-/1-2/-18-1, 2-/3-4-5/-19-2, 2-/5/-19-3, 2-/6-7/-20-4, 2-/7/-20-5,	100%

					<p>2-/8-9-10/21-6 дугаартай 6 хайрцаг, гэрээний хуудас 1 хайрцаг нийт 7 хайрцаг битүүмжлэгдсэн материалыг Тагнуулын газарт хадгалсан байна. Шалгалтын материал нь битүүмжлэл сайтай, лац тэмдэг нь хөндөгдөөгүй байсан. Шалгалтыг Жаргалант сумын 2 дугаар сургууль дээр зохион байгуулсан бөгөөд 27 анги танхимд ширээг дугаарлаж, хүрэлцээтэй байдлыг хангаж, анги танхимыг 100% дуу, дүрсний шаардлага хангасан хяналтын камераар камержуулсан байна. Боловсролын үнэлгээний төвөөс ирсэн ажлын хэсгийнхэн Элсэлтийн шалгалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд шалгалтын байр, анги танхимын бэлэн байдлыг хангаж, 10 зохион байгуулагч, 52 хянагч багшид 2025 оны 06 сарын 17-ны өдөр сургалт зохион байгуулсан. Боловсролын яамны Салбарын хяналтын газарт Урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн тухай танилцуулгыг хавсралт хүснэгтийн хамт Tananerdene@moe.gov.mn цахим хаягаар болон цаасан хэлбэрээр хүргүүллээ. 2024-2025 оны хичээлийн жилд 25</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг 1300 сурагч төгсөж байна. Үүнээс 1047 сурагч Элсэлтийн шалгалтад орохоор бүртгүүлсэн байна. ЭШ-д давхардсан тоогоор 3003 шалгуулагч шалгалтад орохоор бүртгүүлснээс 2736 шалгуулагч буюу 91,1% нь шалгалтанд орж 267 шалгуулагч шалгалтад ороогүй байна.</p> <p>Хүрсэн түвшин: Ерөнхий шалгалт журмын дагуу зохион байгуулагдсан. Шалгалттай холбоотой ямар нэгэн гомдол ирээгүй болно.</p>	
4.5.6	<p>Засгийн газраас баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу Боловсролын сургалтын байгууллагуудад эрсдлийн үнэлгээ хийж, их, дунд үнэлэгдсэн объектуудаас 2026 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх объектийг сонгох</p>	Улсын төсөв	Эрсдлийн үнэлгээнд хамрагдсан объектын тоо	65	<p>Эхний хагас жилд: 65 Жилийн эцэст: 66</p>	<p>Засгийн газраас баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу Ховд аймагт үйл ажиллагаа явуулж буй Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Ерөнхий боловсролын сургуулиудад эрсдлийн үнэлгээг Боловсролын газрын Боловсролын хяналтын улсын ахлах байцаагч Ц.Алтанхишиг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 24-ны өдрийг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэлээ. Сургуулийн өмнөх боловсролын 38 байгууллагын эрсдлийг үнэлгээг Сургуулийн өмнөх</p>	100%

					<p>боловсролын байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтээр үнэлэхэд их эрсдэлтэй-3, дунд эрсдэлтэй-22, бага эрсдэлтэй-13 цэцэрлэг, Ерөнхий боловсролын 25 сургуулийн эрсдлийн үнэлгээг Ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтээр үнэлэхэд их эрсдэлтэй-0, дунд эрсдэлтэй-24, бага эрсдэлтэй-1 сургууль, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтээр Хөгжил политехник коллежийг үнэлэхэд дунд эрсдэлтэй, Их, дээд сургууль, коллежийн сургалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтээр МУИС-ийн Баруун бүсийн сургуулийг үнэлэхэд дунд эрсдэлтэй тус тус үнэлэгдсэн байна. Нийт Боловсролын сургалтын 65 байгууллагын эрсдлийн үнэлгээ хийхэд их эрсдэлтэй -3, дунд эрсдэлтэй -48, бага</p>	
--	--	--	--	--	---	--

						<p>эрсдэлтэй -14 объект байна. Эрсдлийн үнэлгээгээр их, дунд үнэлэгдсэн объектуудаас 2026 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх 10 объектийг сонголоо. Үүнд: Жаргалант сумын 3, 12, 13-р цэцэрлэг, Булган сумын 3-р цэцэрлэг, Дуут сумын цэцэрлэг, Булган сумын 1-р сургууль, Дөргөн сумын ЕБС, Зэрэг сумын ЕБС, Мөнххайрхан сумын ЕБС, Цэцэг сумын ЕБС.</p> <p>Хүрсэн түвшин: 65 байгууллага</p>	
4.5.7	<p>Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх</p>	Улсын төсөв	Ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь	0	<p>Эхний хагас жилд: 50% Жилийн эцэст: 85%</p>	<p>Тайлангийн хугацаанд Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийлээ. Үүнд: Монгол улсын Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвөөс -1 гомдол, мэдээлэл, Ховд аймгийн Засаг даргын тамгын газар, үйлчилгээний нэгдсэн /7043-1111/ төвөөс 5 гомдол мэдээлэл, иргэдээс ирүүлсэн 6 нийт 12 гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллаа. Ирсэн гомдолтой холбоотой 1 иргэнд Зөрчлийн хэрэг нээж Зөрчлийн тухай хуулийн дагуу 20 нэгжээр торгох</p>	100%

						<p>шийтгэл ногдуулж 20000 төгрөгийн бүрэн барагдууллаа. Прокурорын газрын Прокурорын тогтоолын дагуу зөрчлийн хэрэг нээж 1 хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу 400 нэгжээр торгох шийтгэл ногдуулж 400000 төгрөгийг бүрэн барагдуулж ажиллаа.</p> <p>Хүрсэн түвшин: Иргэдийн төрийн байгууллагад гаргадаг өргөдөл гомдол багассан</p>	
4.5.8	Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагууд дотоод хяналтыг нэвтрүүлэх асуудлаар сургалт зохион байгуулах, соён гэгээрүүлэх	Улсын төсөв	Хамрагдсан байгууллагын тоо	180	Эхний хагас жилд: 200 Жилийн эцэст: 200	<p>Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан 10 байгууллагын 350 гаруй удирдлага, багш, ажилтангуудад Дотоод хяналт шалгалтыг үйл ажиллагаандаа тогтмолжуулах нь сэдэвт сургалтыг танхимаар зохион байгууллаа. Дотоод хяналт шалгалтыг хийснээр байгууллагын зорилго зорилтод нөлөөлөх эрсдэлийг тодорхойлж, үр нөлөөтэй, хараат бус, бие даасан дотоод хяналт шалгалтын тогтолцоог бий болгосноор олон эерэг үр дүн гардаг.</p> <p>Хүрсэн түвшин: Байгууллагынхаа үйл ажиллагаанд тохирсон дотоод</p>	100%

						хяналт болсон	шалгалтыг	хийдэг
--	--	--	--	--	--	------------------	-----------	--------

Үнэлсэн:

БОЛОВСРОЛЫН САЙД

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/П.НАРАНБАЯР/

.....

(огноо)

Тайлагнасан:

БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН ДАРГА

(албан тушаал)



(гарын үсэг)

/Б.ЦЭРЭНДАВАА/

(огноо)